



АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Улаанбаатар хот

2013 оны 6 дугаар сар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ НЭГДСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**Аудитыг гүйцэтгэж,
тайланг бэлтгэсэн:**

**ҮАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын газар**

Газрын захирал
Б.Баттуяа

Хэлтсийн захирал,
менежер
Г.Гүнжидмаа
Г.Нямдорж

Ахлах аудитор
Д.Цэрэндорж
Л.Эрдэнэчулуун
С.Сэрчхорол
Д.Баттулга

Аудитор
Б.Саруул
Ш.Энхтайван
Ц.Цолмон
Ц.Эрдэнэчулуун
Ш.Ичинхорлоо
Д.Уртнасан
Б.Даваабаатар
Р.Цолмон

2013 оны 6 дугаар сар

**Уг тайланг ҮАГ-ын
Веб сайтаас үзнэ үү:
www.mnao.mn**

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 263755, 261805,
261456 дугаарын утас,
323266 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:
Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр,
Улаанбаатар хот 15160
МОНГОЛ УЛС

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт		2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй		3
Бүлэг 1. Монгол Улсын 2012 оны төсвийн зорилт, бүрэлдэхүүн, онцлог, тэнцэл		
1.1	Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсөв	5
1.2	Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн	5
1.3	Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн онцлог	5
1.4	Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн тэнцэл	5
1.5	Төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал	6
Бүлэг 2. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн орлого, гүйцэтгэл		
2.1	Нэгдсэн төсвийн орлого, гүйцэтгэл	7
2.2	Улсын төсвийн орлого, гүйцэтгэл	9
2.3	Орон нутгийн төсвийн орлого, гүйцэтгэл	12
2.4	Хүний хөгжил сангийн орлого, гүйцэтгэл	15
2.5	Нийгмийн даатгалын сангийн орлого, гүйцэтгэл	16
Бүлэг 3. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл		
3.1	Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт	18
3.2	Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл	23
3.3	Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл	26
3.4	Хүний хөгжил сангийн зарлагын гүйцэтгэл	27
3.5	Нийгмийн даатгалын сангийн зарлагын гүйцэтгэл	29
Бүлэг 4. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцэл		31
Дүгнэлт		37
Зөвлөмж		38
Хавсралт		39
Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал		42

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АБТ	Агаарын бохирдлын төлбөр
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
БНҮҮС	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ГТГАТТХ	Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хууль
ГАТЧТХ	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗТБХБС	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НДС	Нийгмийн даатгалын сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОАТ	Орлогын албан татвар
ОССК	Орон сууц санхүүжилтийн корпораци
ОУВС	Олон улсын валютын сан
ӨНАМНАТ	Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТХОХЗГ	Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт, зохицуулалтын газар
ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
ТТБТХ	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хүний хөгжил сан
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УНДЕГ	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
УТОХГ	Улсын төсвийн орлого хяналтын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭСЯ	Элчин сайдын яам
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Төсвийн тухай хуулийн 8.10.2-т заасны дагуу Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

- Тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/,
- Татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт,
- Тухайн жилийн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл,
- Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/,
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга.

Сангийн яам Монгол Улсын 2012 оны төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 8.10.1-т заасан хугацаанаас 5 хоног хоцроон тайлагнаж, Үндэсний аудитын газарт 2013 оны 5 дугаар сарын 15-нд ирүүлсэн.

Сангийн яам Монгол Улсын нэгдсэн төсвийн 2012 оны гүйцэтгэлийн танилцуулгыг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд:

- Монгол Улсын эдийн засгийн 2012 оны төлөв байдал
- Төсвийн тогтвортой байдлын тусгай шаардлага
- Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл
- Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагчаар/
- Засгийн газрын гадаад өрийн тухай, гадаад зээлийн эргэн төлөлт
- Засгийн газрын дотоод өрийн тухай
- Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон төсвийн зээлийн талаар
- Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн гүйцэтгэл
- Орон нутгийн 2012 оны төсвийн гүйцэтгэл
- Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн гүйцэтгэл

Танилцуулгын хавсралт мэдээлэлд:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2012 оны гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт /төсвийн бүрэлдэхүүн тус бүрээр/
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2012 оны үр дүнгийн үзүүлэлт /2005-2012 онуудын харьцуулалт, ДНБ-д эзлэх хувиар/
- Улсын төсвийн 2012 оны үр дүнгийн үзүүлэлт /2005-2012 онуудын харьцуулалт, ДНБ-д эзлэх хувиар/
- Улсын 2012 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл /2008-2012 онуудын харьцуулалт, ДНБ-д эзлэх хувиар/
- Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл /эдийн засгийн ангиллаар, төсвийн бүрэлдэхүүн тус бүрээр/
- Улсын 2012 оны төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /2008-2012 онуудын харьцуулалт/
- Улсын 2012 оны төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /орлого төвлөрүүлэгч байгууллагаар/
- Улсын 2012 оны төсвийн зарлагын гүйцэтгэл /төсвийн ерөнхийлөн захирагч, эдийн засгийн ангиллаар/
- Улсын төсвөөс санхүүжүүлсэн 2012 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг тус тус харуулсан байна.

Сангийн сайдын 2009 оны 171 дүгээр тушаалаар баталсан “Улс, орон нутгийн төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын 1.3-д “Улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагыг мөнгөн суурьтай бүртгэлийн зарчмаар хүлээн зөвшөөрч тайлагнана” гэж заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг мөнгөн сууриар тооцож тайлагнасан байна.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг гүйцэтгэхдээ аудитын олон улсын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгосны зэрэгцээ холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын тайланг боловсруулсан бөгөөд аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1. Монгол Улсын 2012 оны төсвийн зорилт, бүрэлдэхүүн, онцлог, тэнцэл

1.1. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсөв:

- Төсвийн тусгай шаардлагуудыг хангаж, зорилтот түвшинд хүргэх;
- Төсвийн тухай хуулийн зарим заалт хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан төсвийн шинэтгэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Төсвийн тухай хуулиар заасан орон нутгийн бие даасан байдлыг санхүүгийн хувьд бэхжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- ДНБ-д ногдох төсвийн зарлагын хэмжээг үе шаттай бууруулах;
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй зарим хөтөлбөр, арга хэмжээг боловсронгуй болгох, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнг сайжруулах, хэмнэлттэй зохион байгуулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх үндсэн зорилттой байжээ.

1.2. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн:

- Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Хүний хөгжил сангийн болон Нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэж байна.

1.3. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн онцлог:

- Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар төсвийг боловсруулах, батлах, тайлагнах, баталгаажуулах цаглабарыг мөрдөж эхэлсэн;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс хуримтлал үүсгэх зорилгоор гол нэр төрлийн эрдэс баялгийг тэнцвэржүүлсэн үнээр тооцож Тогтворжуулалтын санд 94.7 тэрбум төгрөг хуримтлуулсан;
- Мөн уг хуулийн 19.3-д заасны дагуу 2012 оны хувьд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн улсын өр ДНБ-ий 60.0 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагыг баримтласан;
- ЗГҮАХ-т тусгасны дагуу төрийн албан хаагчдын цалин, өндөр настны болон бусад тэтгэврийг 2012 онд хоёр үе шаттай нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлсэн;
- Орон нутгийн бие даасан байдлыг дээшлүүлэх, хүн амын дийлэнх оршин суугаа нийслэл хотын дэд бүтэц, агаарын бохирдол, хот төлөвлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд зориулан тодорхой хөрөнгийг төсөвт тусган хэрэгжүүлсэн;
- Бүс, орон нутгийн онцлогт нийцүүлэн улсын төсвөөс үзүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлсэн;
- Хүний хөгжил сангаас иргэн бүрт 128.0 мянган төгрөгийн тэтгэмж олгохоор шийдвэрлэж хэрэгжүүлсэн байна.

1.4. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн тэнцэл:

- Нэгдсэн төсвийн 2012 оны тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ тооцоолсноос 13.4 хувиар буюу 755.7 тэрбум төгрөгөөр тасарсан, нийт зарлага 6,017.8 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 1,136.6 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.
- Төсвийн орлогын гүйцэтгэлтэй уялдуулан зардлыг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлээгүйгээс нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал ДНБ-ий 8.2 хувьд хүрсэн нь сүүлийн жилүүдийн хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

1.5. ТХМ-ийн шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:
УИХ-аас баталсан¹ 2012 төсвийн талаарх шалгуур үзүүлэлт хэрхэн хангасан байдлыг харуулбал:

Хүснэгт №1

№	Шалгуур үзүүлэлт	2012 оны		Зөрүү	Тайлбар
		хүрэх түвшин	хүрсэн түвшин		
1	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого хэмжээ /тбм.төг/ ▶ ДНБ-д эзлэх хувь	5,825.7 36.1	4,881.2 35.0	- 944.5 - 1.1	Тооцоолсон орлого 944.5 тэрбум төгрөгөөр буюу 16.0 хувиар тасарч, УИХ-аас баталсан шалгуурыг хангаагүй байна.
2	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тбм.төг/ ▶ ДНБ-д эзлэх хувь	6,309.5 39.1	6,017.8 43.2	- 291.7 4.1	Зарлага хэмнэгдсэн ч ДНБ-д эзлэх хэмжээ 4.1 хувиар хэтэрсэн нь орлогын гүйцэтгэлтэй уялдаагүй, УИХ-аас тогтоосон шалгуурыг хангаагүй байна.
3	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /хувь/	27.9%	20.4%	-	-
4	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тбм.төг/ ▶ ДНБ-д эзлэх хувь	-483.8 - 3.0%	-1,136.6 - 8.2%	- 652.8 - 5.2%	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал ДНБ-ий -8.2 хувьд хүрснээр УИХ-аас тогтоосон шалгуурыг хангаагүй байна.
5	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тбм.төг/ ▶ ДНБ-д эзлэх хувь	2,001.0 12.4%	1,525.3 11.0%	- 425.7 - 1.4%	
6	Улсын өрийн нийт хэмжээ /тбм.төг/ ▶ ДНБ-д эзлэх хувь	5,700.0 35.3%	7,374.3 52.9%	1,674.3 18%	УИХ-аас тогтоосон шалгуурыг хангаагүй байна.
7	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжих зардлын нийт хэмжээ /тбм.төг/ ▶ ДНБ-д эзлэх хувь	222.5 1.4%	227.2 1.6%	4.7 -	-

Эх сурвалж: Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамны тооцоололд суурилав.

- УИХ-аас 2012 оны ТХМ-д ДНБ-ий бодит өсөлт 19.7 хувь байхаар баталсан ч гүйцэтгэлээр 12.3 хувь буюу 7.4 пунктээр бага гарсан байна.
- Сангийн яам, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо /хуучин нэрээр/ 2012 оны төсвийн төслийг боловсруулахдаа тухайн жилийн ДНБ-ий өсөлтийг оны үнээр 16.1 их наяд төгрөгт хүрэхээр тооцоолсон боловч гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан зорилтот түвшинд хүрээгүй байна.

¹ Монгол Улсын нэгдсэн төсвийн 2012 оны төсвийн хүрээний мэдэгдэл

Бүлэг 2. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн орлого, гүйцэтгэл

2.1. Нэгдсэн төсвийн орлого, гүйцэтгэл

Төсвийн орлогын төлөвлөгөөний талаар. Төсвийн орлогын төслийг боловсруулахдаа 2011 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, орлогын боломжит эх үүсвэрийг дайчлах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн өсөлт, гадаад, дотоод орчны нөлөөлөл зэргийг тооцож, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг ТХМ-ээс 2,176.1 тэрбум төгрөгөөр, 2011 оны гүйцэтгэлээс 38 хувиар нэмэгдүүлэн 6,352.2 тэрбум төгрөгт хүргэхээр тооцоолсон байна.

Тооцооллын үндэслэлийг авч үзвэл:

- 2011 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлого 107.0 хувиар биелж, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 6.8, гадаад худалдааны бараа эргэлтийн хэмжээ 80.3 хувиар өсч, уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ төлөвлөсөн хэмжээнээс тогтвортой өндөр байсан.
- ДНБ-ий /оны үнээр/ хэмжээг 2012 онд өмнөх оноос 45.0 хувиар өсгөхөөр төсөөлсөн.
- ЗГҮАХ-т тусгасны дагуу төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмжийг үе шаттай нэмэгдүүлэхээр тооцсон.
- Мөн иргэн бүрт 1.5 сая төгрөгийн хишиг хувь хүртээх зорилтыг дэмжсэн.

Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсөвт оруулсан өөрчлөлт

Хүснэгт №2

/сая төгрөг/

Эдийн засгийн ангилал	Өргөн барьсан	Батлагдсан	Тодотгол 1 тайлбар*	Тодотгол 2 тайлбар**
ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6 733 393,3	6 148 108,5	6 326 097,3	5 738 275,7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	381 194,2	322 445,4	322 445,4	101 350,0
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6 352 199,1	5 825 663,2	6 003 652,0	5 636 925,7
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	6 271 415,1	5 824 879,2	6 002 868,0	5 624 806,2
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	784,0	784,0	784,0	11 085,5
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	80 000,0	-	-	1 034,0

***Тодотгол 1.** Өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт, төгрөгийн ханшийн уналтаас хамаарч цалин, тэтгэврийг нэмэгдүүлэх шаардлага бий болсны дагуу төсвийн байгууллагын албан хаагчдын цалин, Нийгмийн даатгалын болон Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, зарим төрлийн тэтгэмжийг үе шаттай нэмэгдүүлснээр нийт зардал 3.0 хувиар нэмэгдсэн байна. /2012 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

****Тодотгол 2.** Хөрш орон болон дэлхийн зах зээл дээрх нүүрсний эрэлт, үнийн бууралтаас шалтгаалан экспорт тооцоолсон хэмжээнд хүрэхгүй болсон. Түүнчлэн, 2012 оны төсвийн тухай хуулиар 496.4 тэрбум төгрөгийн гарын үсгийн төлбөрийг Эрдэнэс-Тавантолгой ХК-аас авахаар төлөвлөсөн ч гэрээ амжилтгүй болсноос орлогыг төвлөрүүлэх боломжгүй болжээ./2012 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар. Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2012 оны гүйцэтгэлээр 4,975.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 762.5 тэрбум төгрөгөөр буюу 13.3 хувиар тасарсан, харин өмнөх оныхоос 11.1 хувиар буюу 507.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2012 оны гүйцэтгэлээр 4,881.2 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 755.7 тэрбум төгрөгөөр буюу 13.4 хувиар тасарч, 2011 оныхоос 15.2 хувиар буюу 654.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №3

/сая төгрөг/

Төсвийн орлогын ангилал, зүйл	Нэгдсэн төсөв-2012			
	Төл	Гүйц	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5 738 275,7	4 975 828,4	-762 447,3	86,7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	101 350,0	94 656,5	-6 693,5	93,4
1. УТ – ААНОАТ	44 520,0	23 074,3	-21 445,7	51,8
2. ХХС – АМНАТ	17 130,0	18 578,9	1 448,9	108,5
3. ХХС – ӨНАМНАТ	39 700,0	45 731,4	6 031,4	115,2
4. ХХС – ЗГТСангийн үлдэгдэл	-	7 271,9	-7 271,9	-
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5 636 925,7	4 881 171,9	-755 753,8	86,6
А. УРСГАЛ ОРЛОГО	5 624 806,2	4 846 063,9	-778 742,3	86,1
I. ТАТВАРЫН ОРЛОГО	5 007 311,5	4 203 321,5	-803 990,0	83,9
1. Орлогын албан татвар	988 577,4	871 401,5	-117 175,9	88,1
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	591 706,9	674 240,2	82 533,3	113,9
3. Өмчийн татвар	19 286,5	21 929,9	2 643,4	113,7
4. Дотоодын бараа, үйлчилгээний татвар	2 142 783,2	1 642 812,7	-499 970,5	76,7
5. Гадаад худалдааны орлого	565 955,9	327 369,8	-238 586,1	57,8
6. Бусад татвар	699 001,6	665 567,4	-33 434,2	95,2
II. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	617 494,7	642 742,4	2 5247,7	104,1
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	11 085,5	10 426,4	659,1	94,0
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1 034,0	24 681,7	23 647,7	2 387,0


Эх сурвалж: Сангийн яам

Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 86.1 хувь нь татварын, 13.2 хувь нь татварын бус, 0.7 хувь нь хөрөнгийн болон тусламжийн орлогоор тус тус бүрдсэн байна.

“Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн дагуу АМНАТ, ӨНАМНАТ болон ААНОАТ-ын орлого, ЗГТС-гийн үлдэгдэл нийт 94.7 тэрбум төгрөгийг Тогтворжуулалтын санд төвлөрүүлснээр 335.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Уул уурхайн салбарын орлогын гүйцэтгэлийн талаар. Гол нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний татварын орлого дараах байдалтай байна. Үүнд:

Зураг №1



Уул уурхайн салбараас орсон татварын орлогын хэмжээ 2012 оны гүйцэтгэлээр 834.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 347.5 тэрбум төгрөгөөр буюу 29.4 хувиар буурч, нийт орлогын 81.2 хувь зэс, нүүрснээс төвлөрсөн байна.

2.2. Улсын төсвийн орлого, гүйцэтгэл

Улсын төсвийн орлогыг 4,364.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 3,481.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, 883.0 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №4

(тэрбум төгрөг)

	ҮЗҮҮЛЭЛТ	2012 он			Эзлэх хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
	Нийт орлого ба тусламжийн дүн	4,364.2	3,481.2	(883.0)	100.0
	Тогтворжуулалтын сан	101.4	94.7	(6.7)	2.7
1	Урсгал орлогын дүн	3,878.8	3,035.0	(843.8)	87.2
	Татварын орлого	3,444.4	2,585.6	(858.8)	74.3
	Татварын бус орлого	434.4	449.4	15.0	12.9
2	Хөрөнгийн орлого				
3	Тусламжийн орлого	384.0	351.5	(32.5)	10.1

Улсын төсвийн орлогын 87.2 хувийг урсгал орлого эзэлж байгаа бөгөөд уг орлогын зонхилох хэсгийг татварын орлого бүрдүүлж байна.

Татварын орлого. 2012 онд улсын төсөвт 3,444.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,585.6 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 858.8 тэрбум төгрөгөөр тасалсан ба Тогтворжуулалтын санд 101.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 6.7 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлжээ.

УТОХГ-т бүртгэлтэй 429 ААНБ-аас 1,499.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 1,273.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 226.3 тэрбум төгрөгөөр тасалжээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. ААНОАТ-аар 2012 онд 658.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 524.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 134.3 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

ААНОАТ-ын орлогын төлөвлөгөө дутуу биелсэн нь уул уурхайн голлох нэрийн бүтээгдэхүүн болох зэсийн зах зээлийн дундаж үнэ 7900 ам.доллар болсон, нүүрснийх 66-135 ам.доллараар буурснаас голлон нөлөөлсөн байна.

ААНОАТ-ын төлөвлөсөн орлогын биелэлтэд томоохон 172 ААНБ-ын 220.4 тэрбум төгрөгийн орлого дутуу, 32 ААНБ 5.0 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлээгүй, мөн алдагдалтай болон дампуурлын хэрэг үүсгэсэн 6 ААНБ-аас төвлөрүүлэхээр тооцсон орлого тасарсан нь тус тус нөлөөлсөн байна.

2012 онд татварын байгууллагад тайлан ирүүлэх 82.5 мянган ААНБ-аас 69.5 мянган ААНБ тайлангаа ирүүлж, татварт хамруулалт 84.2 хувьд хүрсэн байна. Гэвч тайлангаа ирүүлсэн ААНБ-ын 44.9 хувь буюу 37.0 мянган ААНБ үйл ажиллагаа явуулаагүй, алдагдалтай ажилласан байна.

Төрийн болон төрийн өмчийн оролцоотой 98 ААНБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 38 ААНБ алдагдалтай ажиллажээ.

Тайлант онд ААНБ-ын орлогын албан татвараар авах авлага 115.4 тэрбум төгрөг байгаагийн 46.2 тэрбум буюу 40.0 хувийг Монголын алт МАК, 21.2 тэрбум төгрөг буюу 18.4 хувийг Эрдэнэт үйлдвэр ХХК-иас авах авлага эзэлж байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар. Улсын төсөвт 2012 онд 1,296.5 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 437.6 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

НӨАТ-ын төлөвлөсөн орлогын биелэлтэд томоохон 154 ААНБ-ын 145.0 тэрбум төгрөгийн орлого дутуу, 29 ААНБ-ын 9.1 тэрбум төгрөгийн татварыг хурааж чадаагүй нь нөлөөлсөн байна.

2012 онд НӨАТ төлөгч 21.1 мянган ААНБ-ын 94.4 хувь нь тайлан ирүүлснээс татвар төлөгчдийн 24.7 хувь буюу 5.2 мянган татвар төлөгч үйл ажиллагаа явуулаагүй Х тайлан ирүүлсэн ба 718.8 тэрбум төгрөгийн НӨАТ ногдуулж, 36.4 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.


Импортын хэмжээ 2012 оны гүйцэтгэлээр 6.7 тэрбум ам.доллар буюу өнгөрсөн оноос 1.0 хувиар буурсан нь импортын НӨАТ-ын орлогын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлсөн байна.

Онцгой албан татварын орлого. 2012 онд ОАТ-ын орлогыг өнгөрсөн оны гүйцэтгэлээс 82.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 376.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн ч 64.0 тэрбум төгрөгөөр тасарчээ.

УТОХГ-т орлого төвлөрүүлдэг АПУ, Жем интернейшнл, М Си Эс Азий Пасифак брүэри, М Ти Эс, Спирт бал бурам, Улаанбаатар спирт, Чингис шар айраг, Монгол тамхи интернейшнл, Монгол тамхи Со компаниудаас авахаар төлөвлөснөөс 25.5-49.8 хувиар буюу 58.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь ОАТ-ын төлөвлөгөөг үндэслэлгүй нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Түүнчлэн дотоодын спирт үйлдвэрлэгч ААНБ-уудын борлуулалтад ногдуулах ОАТ-ыг төлөвлөөгүй байна.

Мөн Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс аймаг, нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Татварын хэлтэс 7.1-48.3 хувиар буюу 838.4 сая төгрөгөөр тасалжээ.

Зураг №2



2012 онд улсын төсөвт дотоодын барааны онцгой албан татварын орлогоор 165.9 тэрбум төгрөг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 44.3 тэрбум төгрөгөөр тасалсан байна. Үүнд: архины онцгой албан татварын төлөвлөгөө 19.8 тэрбум төгрөг буюу 18.3 хувиар, пивоны онцгой албан татварын төлөвлөгөө 9.0 тэрбум төгрөг буюу 34.0 хувиар, тамхины онцгой албан татварын төлөвлөгөө 15.5 тэрбум төгрөг буюу 49.7 хувиар тус тус биелээгүй нь архи үйлдвэрлэгч ААН-үүдийн тоо орон нутагт өмнөх оноос 18.7 хувиар, Улаанбаатарт 45.5 хувиар буурсан нь нөлөөлжээ.

Бусад татвар. Бусад татварын орлогын төлөвлөгөө 15.0 тэрбум төгрөгөөр давсан нь улсын тэмдэгтийн хураамж, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хураамжийн татварын төлөвлөгөө биелсэнтэй холбоотой байна.


Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хураамж. 2012 онд 26.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 28.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, өмнөх оноос 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ-ын хариуцлага нэмэгдэж төлбөрөө хугацаандаа төлдөг болсон, хайгуулын тусгай зөвшөөрөл олгохгүй болсонтой холбоотойгоор шилжүүлэх, хугацаа сунгуулах, шинээр ашиглалтын лиценз болгох, барьцаалах зэрэг үйлчилгээний орлого өссөн нь төлөвлөгөө биелэхэд нөлөөлжээ.

Ан агнах эрхийн зөвшөөрлийн хураамж. 2012 онд БОАЖЯ 740.5 сая, БОНХЯ 2,894.2 сая, нийт 3,634.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2,695.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөө 939.1 сая төгрөгөөр тасарчээ.

Агаарын бохирдлын төлбөр. 2012 онд агаарын бохирдлын төлбөрийн орлогоор улсын төсөвт 25.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 24.1 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 1.2 тэрбум төгрөгөөр тасарчээ.

Зураг №3



АТБӨЯХ-д ногдуулах АБТ-ийн төлөвлөгөө 106.4 хувийн биелэлттэй ч Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Хөвсгөл, Ховд аймаг, нийслэлийн Сонгинохайрхан Багануур, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Татварын хэлтсүүд 9.7-71.9 хувиар буюу 570.9 сая төгрөгийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэн байна.

Түүхий нүүрсний олборлолтоос 23.1 тэрбум төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн ч 20.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Төлөвлөгөөний биелэлтэд томоохон ААНБ болох Саусгоби сэндс, Таван толгой, Монголын алт МАК, Эрдэнэс Таван толгой, МОЭНКО компаниудаас төвлөрүүлэхээр тооцсон төлбөр хийгдээгүйтэй холбоотой байна.

Агаарын бохирдлын суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл эзэмшигчээс 200.0 сая төгрөгийн агаарын бохирдлын төлбөрийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн ч бохирдуулагч бодисын жагсаалтыг Засгийн газар батлаагүйгээс ногдуулах, хураах үйл ажиллагаа хийгдээгүй байна.

Мөн органик уусгагч импортлогчийн эрх авсан аж ахуйн нэгжүүдийн нэр тодорхойгүй, энэ талаар эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас мэдээлэл гарахгүй байгаагаас органик уусгагч импортлогчоос улсын төсөвт төвлөрүүлэх 60.0 сая төгрөг 2012 онд төвлөрөөгүй байна.

Татварын бус орлого. Татварын бус орлогоор улсын төсөвт 434.4 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 449.4 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 103.4 хувиар биелжээ.

Монголбанкны ашиг. 2012 онд Монголбанкны ашгаас улсын төсөвт 20.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төсвийн тухай хуулиар баталсан боловч Монголбанк хуулийн энэ заалтыг хэрэгжүүлээгүйгээс төсвийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Ногдол ашиг. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын ногдол ашгаар 2012 онд улсын төсөвт 10.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 12.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөө 1.5 тэрбум төгрөгөөр давсан байна.

Гэвч Улаанбаатар төмөр зам ХНН, Монгол шуудан, Био комбинат, ДЦС-2 ТӨХК-ийн төвлөрүүлээгүй болон 8 ААНБ-ын дутуу төвлөрүүлсэн 1.3 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж, тухайн аж ахуйн нэгжийн удирдлагад хариуцлага тооцох нь зүйтэй байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлого. Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 2011 оны гүйцэтгэлээс 42.5 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөсөн ч өөрийн орлого 173.7 тэрбум төгрөг болж, төлөвлөгөө 8.3 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Өөрийн орлого төлөвлөгдөөгүй 206 байгууллага 8,670.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн боловч 167 байгууллага 0.1-9,600.0 сая төгрөгөөр төлөвлөгөөг тасалжээ. Байгууллагууд өөрийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлээгүйгээс 28.1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Газрын тосны орлого. 2012 онд газрын тосны орлогоор 103.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээс 108.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ.

2012 онд шинээр Вольфпетролеум ХХК, МАК ХХК “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулан, гарын үсэг зурсны урамшуулал болон талбайн дэнчингийн төлбөр төлсөн, зарим компаний хайгуул, ашиглалтын гэрээний хугацааг сунгасан, түүхий тосны үнэ төлөвлөсөн үнээс 10 орчим ам.доллараар нэмэгдсэн нь орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэхэд нөлөөлсөн.

2.3. Орон нутгийн төсвийн орлого, гүйцэтгэл

Төлөвлөлтийн талаар. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар улсын төсвөөс орон нутагт 151.7 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгох, орон нутгийн төсвөөс улсын төсөвт 280.8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр баталсан байна.

Орон нутгийн төсвийн нийт орлогыг анх 500.9 тэрбум төгрөгөөр баталж байсан бол тодотголоор 867.5 тэрбум төгрөг, үүнээс урсгал орлогыг 707.7, хөрөнгийн орлогыг 11.1, тусламжийн орлогыг 151.7 тэрбум төгрөг болгож баталсан байна.

Орон нутгийн төсвийн давсан орлогыг аймаг, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор олон дахин тодотгох, зардлаа өсгөж батлах, төсвөө

хэтрүүлэн зарцуулах явдал Завхан, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий зэрэг аймагт гарсан байна.

Төсвийн тодотгол хийхдээ орлогын нэр төрлийг заахгүй, сумын ИТХ-аар бус Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэх, төсвийн мэдээллийг аймагтаа өгөөгүйгээс тухайн аймгийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл зөрүүтэй тайлагнагдах явдал давтагдсаар байна.

Гүйцэтгэлийн талаар. Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 858.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 68.2 хувиар өссөн боловч төлөвлөгөө 1.1 хувиар буюу 9.5 тэрбум төгрөгөөр тасарчээ.

Орон нутгийн төсвийн орлогын 71.4 хувийг татварын, 9.7 хувийг татварын бус, 17.7 хувийг тусламжийн, 1.2 хувийг хөрөнгийн орлого бүрдүүлж байна.

Аймаг, нийслэлийн төсвийн 2012 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт № 5

Аймаг, нийслэл	Төсвийн орлого			Аймаг, нийслэл	Төсвийн орлого		
	Төл	Гүйц	Хувь		Төл	Гүйц	Хувь
Архангай	9,103.8	9,705.6	106.6	Өмнөговь	140,259.6	109,452.6	78.0
Баян-өлгий	7,429.9	8,593.0	115.6	Сүхбаатар	9,312.3	9,893.6	106.2
Баянхонгор	10,146.2	10,510.2	103.6	Сэлэнгэ	20,800.5	18,077.7	86.9
Булган	12,540.8	13,608.4	108.5	Төв	12,140.8	14,673.0	120.9
Говь-Алтай	10,188.6	10,740.5	105.4	Увс	9,380.9	10,372.3	110.6
Говьсүмбэр	3,697.5	4,140.2	111.9	Ховд	9,160.1	10,201.2	111.4
Дорноговь	14,344.9	14,594.7	101.7	Хөвсгөл	12,029.1	12,984.4	107.9
Дорнод	8,885.4	9,078.2	102.2	Хэнтий	8,676.9	9,382.9	108.1
Дундговь	7,045.4	7,422.9	105.4	Дархан-уул	13,667.0	12,638.0	92.5
Завхан	9,793.9	10,504.9	107.2	Улаанбаатар	438,675.2	455,786.5	103.9
Өвөрхангай	11,199.5	11,595.1	103.5	Орхон	88,464.6	84,068.2	95.0
Бүгд дүн					867,542.9	858,024.1	98.9

Татварын орлого. Орон нутгийн төсөвт 631.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 18.8 тэрбум төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон зэрэг аймгийн орлогын төлөвлөгөө 1.0-27.4 тэрбум төгрөгөөр тасарсан нь АМНАТ, түгээмэл тархацтай болон байгалийн нөөцийн төлбөрийг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Орлогын албан татвар. Хүн амын орлогын албан татвараар 347.0 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 5,2 хувиар буюу 17.1 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Энэ нь өмнөх оноос 115.9 тэрбум төгрөг буюу 50.2 хувиар өссөн байна.

Орлогын албан татварын биелэлтэд цалин хөлсний орлогод ногдуулах албан татвар 10.9, хувиараа аж ахуй эрхлэгчдийн орлогын татвар 1.8, орлогыг нь тодорхойлох боломжгүй иргэний татвар 0.2, хүн амын албан татварын бусад орлого 4.2 тэрбум төгрөгөөр давсан нь нөлөөлжээ.

Бусад татвар, төлбөр хураамжийн бүрэлдэхүүнийг харуулбал,

Хүснэгт №6

/сая төгрөг/

Орлогын нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувиар/
1. Улсын тэмдэгтийн хураамж	30,004.1	28,566.0	95.2
2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	100,234.3	63,100.6	62.9
3. Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	53,651.6	48,356.3	90.1
4. Газрын төлбөр	39,957.6	44,588.5	111.6
5. Рашаан ус ашигласны төлбөр	3,083.4	2,671.8	86.6
6. Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөр	2,469.6	2,909.5	117.8
7. Агнуурын нөөц ашигласны төлбөр	340.9	444.1	130.3
8. Ашигт малтмалаас бусад баялаг ашиглах эрхийн төлбөр	893.9	921.7	103.9
9. Ус ашигласны төлбөр	9,826.8	9,411.1	95.8
10. Лицензийн төлбөр	14,085.0	14,060.6	99.8
11. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	5,201.1	4,532.4	87.1
12. Бусад татвар хураамж	818.9	1,069.5	130.5
13. Байгалийн ургамал ашигласны төлбөр	47.8	36.1	75.5
Бусад татварын дүн	260,615.2	220,668.4	84.7

Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын төлөвлөгөө 5.1 хувь буюу 1.5 тэрбум төгрөгөөр тасарсан нь Орхон 137.0 сая, Дорнод 0.9 сая төгрөгөөр дутуу, нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Налайх дүүрэг хураамжийн төлөвлөгөөг үндэслэл муутай төлөвлөсөнтэй холбоотой байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны болон өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө 1.6 хувь буюу 0.2 тэрбум төгрөгөөр тасарсан байна. Энэ нь 11 аймаг түүний дотор Өмнөговь 29.3, Сэлэнгэ 2.6, Орхон 3.1, Дархан-Уул аймаг 1.7 тэрбум төгрөг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Орхон аймаг 7.9 тэрбум төгрөгийн орлогыг үндэслэлгүй төлөвлөсөн, Өмнөговь аймгийн нүүрсний экспорт багассан, Сэлэнгэ аймаг Бороогоулд ХХК-иас 3.1 тэрбум төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна.

Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс Цайрт минерал ХХК-ийн 2012 онд олборлосон бүтээгдэхүүний үлдэгдэл 17.1 мянган тонн цайрын баяжмалаас нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт хийж төсөвт төвлөрүүлээгүй байна.

Рашаан ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг нийслэл 393.9, Дархан-Уул аймаг 66.7, Говь-Алтай аймаг 5.1, Хөвсгөл аймаг 1.0 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуульд “Аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон улсын байцаагч ус ашигласны төлбөрийг хураана. Төлбөрийн хэмжээг Засгийн газраас тогтооно” гэж заасан боловч төлбөрийн хэмжээг тогтоосон шийдвэр гараагүйтэй холбоотой байна.

Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг Ховд 5.2, Хөвсгөл 4.1, Төв 2.3, Говь-Алтай 1.2 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, түгээмэл тархалттай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг Сэлэнгэ 579.0, Ховд 83.1, Өмнөговь 84.2, Хөвсгөл 41.9, Архангай 37.1 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Татварын бус орлого. Орлогын төлөвлөгөө 113.7 хувь буюу 10.0 тэрбум төгрөгөөр давсан нь хүү, торгуулийн болон төсөвт байгууллагын өөрийн орлого, бусад нэр заагдаагүй орлого төлөвлөснөөс илүү бүрдсэнтэй холбоотой байна.

Татварын бус орлого өмнөх оноос 190.1 сая төгрөгөөр илүү төлөвлөгдсөн байхад 148.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь татварын бус орлогыг нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна.

Хөрөнгийн орлого. Хөрөнгийн орлогын төлөвлөгөө 659.1 сая төгрөгөөр тасарсан нь Архангай 17.1, Завхан 20.0, Ховд 126.1, Дундговь 75.2, Орхон аймаг 784.8, Нийслэл 391.6, сая төгрөгөөр төлөвлөгөөгөө дутуу биелүүлсэнтэй холбоотой байна.

Тусламжийн орлого. Улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгээр 2011 онд 11 аймагт 29.4 тэрбум төгрөг олгож байсан бол 2012 онд 14 аймагт 151.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 122.3 тэрбум төгрөгөөр буюу 5 дахин нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 236.8 тэрбум төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 84.3 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын биелэлтийг харуулбал,

Хүснэгт №7

/сая төгрөг/

Д.д	Аймгийн нэр	2012 он				
		Төлөвлөгөө		Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
		Анх батлагдсан	Тодотгосон			
1	Говь-Алтай	293.9				
2	Дорноговь	3,995.2	3,521.2	3,521.1		100.0
3	Дорнод	1,093.1	629.3	629.3		100.0
4	Өмнөговь	118,841.3	106,161.6	75,527.0	-30,634.6	71.1
5	Сүхбаатар	34.1				
6	Сэлэнгэ	9,854.7	9,289.5	4,000.0	-5,289.5	43.0
7	Ховд	1,046.9				
8	Хэнтий	570.3	30.2		-30.2	
9	Дархан-Уул	7,910.5	6,368.7	5,222.3	-1,146.4	82.0
10	Орхон	74,523.8	80,841.7	73,971.3	-6,870.4	91.5
11	Улаанбаатар	70,000.0	70,000.0	70,000.0		100.0
12	Булган		3,937.5	3,937.5		100.0
	Нийт дүн	288,163.7	280,779.7	236,808.5	-43,971.2	84.3

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Орхон аймаг 8.5-57.0 хувиар тасалсан нь төвлөрүүлэх нийт орлого 15.7 хувь буюу 43.9 тэрбум төгрөгөөр тасрах шалтгаан болжээ.

2.4. Хүний хөгжил сангийн орлого, гүйцэтгэл

Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар ХХС-гийн төсвийн орлого болон урьдчилгаа төлбөрийг анхны батлагдсан төсвөөс 257.6 тэрбум төгрөгөөр бууруулж баталжээ.

ХХС-гийн орлогын эх үүсвэрийг бууруулан баталсан нь Тавантолгойн нүүрсний ордын баруун Цанхийн хэсгийг ашиглах, хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын концерциумыг сонгон шалгаруулах гэрээ байгуулах хэлэлцээр амжилтгүй болсонтой холбоотой байна.

Гүйцэтгэлийн талаар. ХХС-д нийт 449.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас 441.0 тэрбум төгрөг төвлөрсөн байна.

Уг санд төвлөрүүлэх ӨНАМНАТ 20.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь нүүрс, төмрийн хүдрийн гадаад зах зээлийн үнэ буурсан, Засгийн газрын 2012 оны 74 дүгээр тогтоолоор нүүрсний үнийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нүүрс борлуулж, экспортод гаргах гэрээний үнээр тооцохоор баталсантай холбоотой байна.

Мөн МХЕГ-аас Чинхуа-МАК Нарийн сухайт, Монголын алт МАК, Саусгоби сэндс ХХК-иудын ил уурхайгаас хилийн боомт хүртэлх хөрсөн замын ашиглалтыг түр хугацаагаар хааснаас тухайн санд төвлөрүүлэх АМНАТ бүрэн төвлөрч чадаагүй байна.

Эрдэнэс МГЛ ХК урьдчилгаа төлбөрт 80.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс Сангийн сайдын 2012 оны 172 дугаар тушаалаар урьдчилгаа төлбөр 16.8 тэрбум төгрөгийг АМНАТ, ӨСНАТ болон улсын төсөвт НӨАТ, АБТ-т тус тус суутган тооцсон.

2.5. Нийгмийн даатгалын сангийн орлого, гүйцэтгэл

2012 онд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд 30.5 мянган ААНБ шимтгэл төлсөн нь өнгөрсөн онтой харьцуулахад байгууллагын тоо 13.8 хувь буюу 3.7 мянгаар, заавал даатгуулагчын тоо 12.5 хувь буюу 82.7 мянган хүнээр тус тус нэмэгджээ.

Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнөх тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг Засгийн газар хариуцах үүрэг болон цэргийн тэтгэвэр авагчдын тэтгэврийн эх үүсвэрт зориулан төсвөөс 272.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус санд төвлөрүүлжээ.

НДС-д 720.2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 799.2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлж, төлөвлөгөө 110.9 хувиар буюу 79.0 тэрбум төгрөгөөр давжээ.

Орлогын гүйцэтгэлийг авч үзвэл:

Хүснэгт №8

/сая төгрөг/

Даатгуулагчийн төрлөөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ААН-ээс төлсөн шимтгэл	245,793.5	334,459.7	-88,666.2	136.07
Төсөвт байгууллагаас төлсөн шимтгэл	116,490.6	106,762.7	9,727.9	91.65
Ажиллагсдаас төлсөн шимтгэл	312,098.9	298,975.9	13,122.9	95.80
Нөхөн олговор авагчдын шимтгэл	6.2	4.2	2.0	67.01
Сайн дурын даатгуулагчаас төлсөн шимтгэл	13,800.0	17,072.2	-3,272.2	123.71
Гадаад улсад ажиллаж буй иргэдийн төлсөн шимтгэл	1,500.0	1,473.2	26.8	98.21
ҮОМШӨС-гаас төлсөн шимтгэл	756.7	712.8	43.9	94.20

Төр бүрэн хариуцах даатгуулагчийн шимтгэл	12,151.5	12,151.5	0.00	100.00
Бусад даатгуулагчаас төлсөн шимтгэл	2,126.9	4,041.5	-1,914.5	190.01
ДҮН	720,213.3	799,221.9	-79,008.6	

НДС-гийн нийт орлогын 41.2 хувийг ажил олгогчийн, 29.5 хувийг даатгуулагчийн төлсөн шимтгэлээр, 25.4 хувийг тэтгэврийн даатгалын санд олгосон улсын төсвийн санхүүжилтээр, 1.1 хувийг ЭМД-ын төр хариуцах иргэдийн шимтгэлээр, 2.8 хувийг бусад эх үүсвэрээр тус тус бүрдүүлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулсан цалингийн сангийн талаар. 2012 онд 4.1 их наяд төгрөгийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогод ногдуулсан шимтгэл өмнөх оноос 46.4 хувиар буюу 1.3 их наяд төгрөгөөр өссөн байна. Нийт өсөлтийн 31.4 хувь буюу 401.7 тэрбум төгрөг нь даатгуулагчийн тооны, 68.6 хувь буюу 878.3 тэрбум төгрөг нь даатгуулагчийн цалингийн дундаж өсөлтөөс хамаарчээ.

Нийт шимтгэл ногдуулсан цалингийн сангийн 3.4 хувийг сайн дурын даатгуулагчдын, 67.0 хувийг ААНБ, 29.6 хувийг төсөвт байгууллага эзэлж байна.

ААНБ-ын цалингийн сан жил бүр өссөн нь сүүлийн жилүүдэд уул уурхай, олборлох үйлдвэрлэл, тээвэр, санхүүгийн үйлчилгээний салбарт ажиллаж буй даатгуулагчдын тоо, дундаж цалингийн өсөлттэй холбоотой байна.

Бүлэг 3. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

3.1. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт

Монгол Улсын 2012 оны төсвийн зарлагын бодлого нь макро эдийн засгийн зорилтод тулгуурлан Засгийн газрын хэрэглээний түвшинг зохистой тодорхойлж төсвийн зарлагыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгджээ.

2012 оны улсын нэгдсэн төсвийн зарлага 6,499.2 тэрбум төгрөгөөр батлагдаж 6,017.8 тэрбум төгрөгийн буюу 92.6 хувийн гүйцэтгэлтэй гарч, ДНБ-ий 43.2 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 6.9 пунктээр буурсан байна.

Хүснэгт №9

Нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэлээс үзэхэд 2012 оны төсвийн зарлагын өсөлт ДНБ-ий сүүлийн 3 жилийн дунджаас 3.0 пунктээр илүү байна.	Үзүүлэлт	Гүйцэтгэл, (тбм.төг)			Өсөлтийн хувь	
		2010	2011	2012	2010/2011	2011/2012
	ДНБ оны үнээр	8 414.5	11 087.7	13 944.2	31.8	25.8
	Нэгдсэн төсвийн орлого, тусламж	3 122.5	4 227.2	4 881.1	35.4	15.5
	Нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийн дүн	3 080.7	4 997.0	6 017.8	62.2	20.4

Улсын нэгдсэн төсвийн 2012 оны зарлагын гүйцэтгэлийг² төсвийн бүрэлдэхүүн болон эдийн засгийн ангиллаар харуулбал:

Хүснэгт №10

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	Нэгдсэн		Улсын		Орон нутгийн		ХХС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	6499.2	6017.8	4675.9	4379.5	950.6	747.2	866.0	848.7	942.2	918.7
Урсгал зарлага	4664.3	4428.1	3227.9	3037.7	567.6	501.2	866.0	848.7	938.4	916.8
Хөрөнгийн зарлага	1849.6	1525.4	1462.9	1277.5	382.9	246.0	0.0	0.0	3.8	1.9
Эргэж төлөгдөх цэвэр зээл	(14.8)	64.3	(14.8)	64.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн 65.7 хувийг улсын төсөв, 9.7 хувийг орон нутгийн төсөв, 13.9 хувийг ХХС, 10.7 хувийг НДС-гийн төсөв тус тус эзэлж байна.

Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл 2012 оны нийт зарлага 2008 оноос 2.4 дахин, өмнөх оноос 1.2 дахин өсчээ.

Хүснэгт №11

(тэрбум төгрөг)

Зардлын бүлэг	2008	2009	2010	2011	2012
Нийт зарлага ба цэвэр зээл, Үүнээс:	2 466.8	2 336.6	3 080.7	4 997.0	6 017.8
Урсгал зардал	1 761.2	1 788.1	2 256.7	3 236.4	4 428.1
Хөрөнгийн зардал	624.4	460.6	590.6	1 280.9	1 525.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	81.2	87.9	233.4	479.7	64.3

² Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө 935.6 тэрбум, гүйцэтгэл 876.3 тэрбум төгрөгөөр тус тус давхардсан гүйлгээгээр нийт дүнгээс зөрж байгаа болно.

2012 онд эргэж төлөгдөх цэвэр зээл 2008 оныхоос 16.9 тэрбум, өмнөх оныхоос 415.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Улсын нэгдсэн төсвийн 2012 оны нийт зарлагын гүйцэтгэлийн 73.5 хувийг урсгал зардал, 25.3 хувийг хөрөнгийн зардал, 1.2 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.

Урсгал зардал. 2012 оны нэгдсэн төсвийн нийт урсгал зарлагад 4,428.1 тэрбум төгрөг зарцуулж, 94.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Урсгал зарлагын гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №12

(тэрбум төгрөг)

Зардлын бүлэг	2008	2009	2010	2011		2012		Эзлэх Хувь
	Гүйц	Гүйц	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	
Урсгал зарлага, Үүнээс:	1,763.2	1788.1	2,256.2	3,334.7	3,236.4	4,664.3	4,428.1	100.0
Цалин, НДШ	544.5	575.9	710.2	806.6	802.4	1,216.4	1,197.2	27.0
Бараа үйлчилгээний бусад зардал	510.5	394.2	518.2	715.5	702.0	944.1	855.3	19.3
Зээлийн хүүгийн төлбөр	19.9	29.6	42.3	38.1	37.3	151.6	125.9	2.8
Татаас ба урсгал шилжүүлэг	688.3	788.4	1,047.6	1,774.5	1,694.5	2,352.2	2,249.8	50.8

2012 оны нэгдсэн төсвийн урсгал зарлагын гүйцэтгэл 2008 оныхоос 2.5 дахин, өмнөх оныхоос 1.4 дахин өсчээ.

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өмнөх оны гүйцэтгэлээс 1.5 дахин өссөн нь төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Зээлийн үйлчилгээний төлбөр. 2012 оны нэгдсэн төсөвт 151.6 тэрбум төгрөгийн зээлийн хүү төлөхөөр төлөвлөснөөс 83.1 хувь буюу 125.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Зээлийн хүүгийн зардлыг бүтцээр нь үзүүлбэл:

Хүснэгт №13

(сая төгрөг)

Үзүүлэлт	2011 оны гүйцэтгэл	2012 оны			Хувь
		Төлөв	Гүйц	Зөрүү	
Гадаадын зээлийн үйлчилгээний төлбөр	26 615.6	29 385.6	28 199.2	-1,186.4	96.0
Дотоодын зээлийн хүү	10 705.4	122 203.7	97 714.2	-24 489.5	80.0
Улсын зээллэгээ, бондын хүү	10 705.4	103 226.4	78 783.7	-24 442.7	76.3
Зээлийн хүүгийн төлбөр	0.0	18 977.3	18 930.5	-46.8	99.8
Зээлийн үйлчилгээний нийт төлбөр	37 321.0	151 589.3	125 913.4	-25 675.9	83.1
Үүнээс: Улсын төсөв	37 321.0	132 612.0	106 982.8	-25 629.2	80.7
ХХС-гийн төсөв	0.0	18 977.3	18 930.5	-46.8	99.8

Сангийн сайдын 2012 оны төсвийн багцад Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын байгууллагаас авч ашиглаж байгаа зээлийн хүүгийн төлбөрт 29.1 тэрбум төгрөг төлөхөөр төлөвлөснөөс 27.9 тэрбум төгрөг төлсөн байна.

2012 онд Засгийн газрын ашигласан зээл, бондын хүүгийн зардалд 103.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс 78.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тухайлбал,

- Төрийн албан хаагчид болон иргэдийг орон сууцжуулах “4000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 2010-2011 онд гаргасан бондын хүүгийн зардалд 12 433.0 сая;
- Банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд өмнөх онуудад гаргасан бондын хүүгийн зардалд 4 733.9 сая;
- Ноос ноолуурын болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 2011 онд гаргасан 286 330.6 сая төгрөгийн болон тайлант онд гаргасан 13 669.4 сая төгрөгийн бондын хүүгийн зардалд нийт 25 702.4 сая;
- Төсвийн алдагдлыг нөхөхөд зориулан тайлант онд гаргасан 554 859.4 сая төгрөгийн бондын хүүгийн зардалд 4 119.2 сая;
- 1991 онд гаргасан өрийн бичгийн хүүгийн төлбөрт 0.9 сая;
- ОУВС-гийн “Стэнд-бай” хөтөлбөрийн хүрээнд Монголбанкинд байршуулсан зээлжих тусгай эрхийн дансанд тооцогдсон хүүгийн зардалд 10.7 сая төгрөг, нийт 47.0 тэрбум төгрөгийг Засгийн газрын дотоод бондын хүүгийн зардалд төлсөн байна.


Засгийн газар болон Хөгжлийн банкнаас олон улсын зах зээлд гаргасан бондын хүүгийн зардлыг дотоодын зээлийн хүүгийн зардлын ангилалд тайлагнажээ. Үүнд:

- Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулиар батлагдсаны дагуу Хөгжлийн банкнаас олон улсын зах зээлд гаргасан 600.0 сая ам.долларын бондын тайлант оны хүүгийн зардал 24 300.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн;
- Засгийн газрын 2012 оны 213 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 297 дугаар тушаалаар Засгийн газрын үнэт цаасыг олон улсад сурталчлах, худалдан борлуулахтай холбогдон гарсан зардал 5,376.8 мянган ам.доллартай тэнцэх эх үүсвэрийг нөхөн санхүүжүүлэхээр шийдвэрлэснийг үндэслэн улсын төсвөөс Монголбанкн дахь “Чингис” бондын харилцах дансанд нотлох баримтгүйгээр 7,483.5 сая төгрөгийг шилжүүлсэн, нийт 31,783.5 сая төгрөгийг Засгийн газрын дотоодын зээлийн хүүгийн зардлаар илэрхийлсэн байна.

Засгийн газрын 2012 оны 24 дүгээр тогтоолын дагуу төсвийн орлого, зарлагын улирлын чанартай зөрүүг нөхөх зориулалтаар Монголбанкнаас авсан зээлийн хүүгийн төлбөрт 18.9 тэрбум төгрөг төлж, ХХС-гийн зардлаар тайлагнажээ.

Татаас ба урсгал шилжүүлгийн зардал. 2012 онд татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 2,352.2 тэрбум төгрөг батлагдсанаас 2,249.7 тэрбум төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 95.6 хувьтай байгаа нь 2008 оныхоос 3.3 дахин, 2011 оныхоос 1.3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг №4



Татаас ба урсгал шилжүүлгийн зардлын өсөлт хөрөнгийн зардлын өсөлтөөс 13.7 хувиар илүү байгаа нь төсвийг хөгжлийн чиглэлд зарцуулж чадаагүйг харуулж байна.

2012 оны татаас ба урсгал шилжүүлгийн зардлын гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад улсын төсвийнх 110.0, орон нутаг 52.6, ХХС 5.5, НДС 56.3 хувиар тус тус нэмэгджээ.

Хүснэгт № 14

/тэрбум төгрөг/

Он	Нэгдсэн төсөв		Улсын төсөв		Орон нутаг		ХХС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
2011	1,618.3	1,571.7	322.9	305.5	172.8	161.5	828.4	786.8	528.9	515.5
2012	2,240.1	2,122.7	732.4	641.5	291.0	246.4	847.1	829.8	814.2	805.8
2012/2011 өсөлтийн хувь	38.4	35.1	126.8	110.0	68.4	52.6	2.3	5.5	53.9	56.3

Улсын төсвөөс нийт 6 ТЕЗ-аар дамжуулан эрчим хүч, дулааны алдагдлыг нөхөхөд 38.0, нийслэлийн нийтийн тээврийн татаасанд 40.6, бусад татаас, шилжүүлэгт 302.4, улаан буудай, махны үнийн татаасанд 15.0, нийт 396.1 тэрбум төгрөг олгохоор тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр 393.7 тэрбум төгрөг зарцуулжээ.

Говь-Алтай, Завхан аймгийн эрчим хүчний үйлдвэр, Баянхонгор, Завхан, Говь-Алтай аймгуудын эрчим хүчний системд холбогдоогүй сумд, “ББЭХС” ТӨХК, “ДБЭХС” ТӨХК, Даланзадгадын ДЦС, Налайх, Багануурын дулааны станц болон Төрийн өмчит эрчим хүчний компаниудад 38.0 тэрбум төгрөгийн татаас олгохоор шийдвэрлэн гүйцэтгэлээр 36.1 тэрбум төгрөг олгогджээ.

Эрчим хүчний компаниудын үйл ажиллагааны алдагдлыг нөхөх зорилгоор улсын төсвөөс нийт 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Иргэдэд олгосон мөнгөн урамшуулал. Засгийн газрын 2012 оны 221, 368 дугаар тогтоолын дагуу 21 аймгийн 332 сум, нийслэлийн 6 дүүргийн нийт 103.1 мянган малчин, мал бүхий иргэдийн тушаасан 14.7 мян.тн ноосонд 29.4 тэрбум төгрөгийн урамшуулал олгожээ.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл. Тодотголоор 6 ТЕЗ-дын төсвийн багцад дотоод эх үүсвэрээс 91.9, гадаад эх үүсвэрээс 18.8 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээл олгох, өмнөх онуудад олгосон зээл, бусад эх үүсвэрээс 125.6 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлэхээр тусгасан байна.

Хүснэгт №15

(сая төгрөг)

ТЕЗ	Байгууллага	2012 он		Зөрүү (2-1)	Эзлэх хувь
		Тодотгосон төсвөөр	Гүйцэтгэл		
Сангийн сайд	Улсын төсвөөс ААН болон төсөвт байгууллагад дамжуулан зээлдүүлсэн зээл (ДЗЗ)-ээс эргэн төлүүлэх	(38 396.6)	(35 246.3)	3150.3	
	Хөгжлийн банкны дүрмийн санг нэмэгдүүлэх	23 600.0	23 600.0	-	
	Зоос банкны эрх хүлээн авагчаас авах авлага	(20 000.0)	(10 252.4)	9 747.6	
	ОССК-д олгосон зээлийн эргэн төлөлт	(10 000.0)	-	10 000.0	
	Зээлийн батлан даалтын сан	5 000.0	5 000.0	-	
	Гадаадын зээлээс санхүүжүүлэх 4 төсөл	11 334.7	52 788.3	41 453.6	
	Дүн	(28 461.8)	35 889.6	64 351.4	55.8
ҮХААС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	(35 000.0)	(25 742.2)	9 257.8	
	Мал хамгаалах сан	2 114.0	2 118.8	4.8	
	Гадаадын зээлээс санхүүжүүлэх төсөл	2 043.3	-		
	Дүн	(30 842.8)	(23 623.4)	9 262.6	-36.7
ХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	51 660.0	48 607.4	(3 052.6)	75.6
БШУС	Сургалтын төрийн сан	9 581.3	6 423.4	(3 157.9)	10.0

ХЗС	Хадгаламж зээлийн хоршооны хохирогчдын төлбөр барагдуулах ажлын алба	(22 177.1)	(2 965.7)	19 211.4	-4.6
ЭХС	Гадаадын зээлээс санхүүжүүлэх төсөл	5 462.7			
Нийт дүн		(14 777.7)	64 331.4	86 615.0	100.0

Тайлант онд эргэн төлөгдөх зээлээс Сангийн яам 45.5, ХЗЯ 2.9, ҮХААЯ 25.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 51.4 тэрбум төгрөг буюу 40.9 хувиар тасалдуулжээ. Үүнд:

- Улсын төсвөөс ААНБ болон төсөвт байгууллагад дамжуулан зээлдүүлсэн зээлээс 3.2 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн;
- Зоос банкны эрх хүлээн авагчаас авах авлагыг төлөвлөснөөс 9.7 тэрбум төгрөгөөр дутуу барагдуулсан;
- Засгийн газрын “4000 орон сууц” хөтөлбөрт зориулан 2010-2011 онд ОССК-д дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлт 2014 оноос эхлэн төлөгдөх гэрээтэй атал 2012 онд 10.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр алдаатай төлөвлөлт хийгдсэн;
- Өмнөх онд улсын төсвөөс ТЭДС-д эргэн төлөгдөх нөхцөлөөр 1 жилийн хугацаатай олгосон зээлээс 9.3 тэрбум төгрөг;
- Дампуурсан Хадгаламж, зээлийн хоршооны хохирогчдын төлбөр барагдуулах ажлын явц удаашралтай байгаагаас 19.2 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Хөгжлийн банкны тухай хуулийн 21.1.1-д заасны дагуу Хөгжлийн банкны дүрмийн санг 23.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, дотоод эх үүсвэрийн зээлээр 23.6 тэрбум төгрөг олгохоор баталж, санхүүжүүлжээ.

Засгийн газрын 2012 оны 141 дүгээр тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Зээлийн батлан даалтын сан”-д 5.0 тэрбум төгрөг олгосон байна.

Сангийн сайдын төсвийн багцад гадаад эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлэх зээл 11.3 тэрбум төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 52.8 тэрбум төгрөг гарч 41.5 тэрбум төгрөгөөр хэтэрсэн, ЭХС болон ҮХААС төсвийн багцад 7.5 тэрбум төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэл гараагүйгээс нийт дүнгээрээ 33.9 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь зээлийн ашиглалтын төлөвлөлт, тайлагнал бодитой бус байгааг харуулж байна.

Мал хамгаалах сангаас сүү, махны чиглэлийн аж ахуй эрхлэгчдэд 1,272.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон, таримал тэжээлийн нэг ба олон наст ургамлын үр, малын тэжээл үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмж, малын тэжээлийн иж бүрдэл худалдан авч, иргэд ААНБ-д 946.3 сая төгрөг, бүгд 2,118.8 сая төгрөг олгосныг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардлаар тайлагнажээ.

ЖДҮХС–гаас өмнөх жилүүдэд олгосон зээлийн эргэн төлөлтөөс 30.1, бондын эх үүсвэрээс 13.6, УИХ-ын гишүүдийн багцаас 0.9, Хөгжлийн банкнаас 8.1, нийт 52.8 тэрбум төгрөг төвлөрүүлж, 48.6 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Үүнд:

- Орон нутгийн зээлийн эх үүсвэрт буюу 68 иргэн, аж ахуйн нэгжид 4 077.7 сая;
- Бүс нутгийн чанартай зээлийн эх үүсвэрт буюу 38 иргэн, аж ахуйн нэгжид 24,741.7 сая;
- Ноос, ноолуурын салбарын зээлийн эх үүсвэрт буюу 13 аж ахуйн нэгжид 18,428.0 сая;
- УИХ-ын гишүүдийн багцаас зээлийн эх үүсвэрт буюу 3 иргэн, аж ахуйн нэгжид 555.0 сая;
- Сүү хөтөлбөр, Түүхий эдийн төв байгуулах болон бусад чиглэлээр 13 иргэн, ААНБ-д бүгд 805.0 сая төгрөгийг олгосон байна.

2012 онд Сургалтын төрийн сангаас магадлан итгэмжлэгдсэн дотоодын их, дээд сургуульд суралцагч оюутнуудад 783.7 сая, гадаадын өндөр хөгжилтэй орны их, дээд сургуульд суралцагсдад 5,639.7 сая, нийт 6,423.4 сая төгрөгийн зээл олгож,

эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд тооцсон нь төлөвлөснөөс 3,157.9 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

Өмнөх онуудад улсын төсвөөс олгосон зээлээс тайлант онд эргэн төлүүлэх 51.3 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, гадаад зээлийн ашиглалтын төлөвлөлтөөс 33.9 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардал хэтрэхэд нөлөөлсөн байна.

3.2. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл

2012 онд ТЕЗ-дын төсвийн зардлын хязгаарыг 3,257.7 тэрбум төгрөгөөр тогтоосон байна. Төсвийн тодотголоор төсвийн зарлагыг төсвийн хязгаараас 1,442.1 тэрбум төгрөгөөр буюу 1.4 дахин нэмэгдүүлж тодотгожээ.

Улсын төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн 20.4 хувийг БШУС, 12.4 хувийг ХАХНХС, 10.1 хувийг ЗТС, 9.7 хувийг ЭМС, 9.6 хувийг Сангийн сайд, 7.2 хувийг ХЗС, үлдсэн 30.6 хувийг бусад ТЕЗ-дын зарлага эзэлж байна.

2012 оны улсын төсвийн зарлагын гүйцэтгэлд урсгал зардал 69.4, хөрөнгийн зардал 29.2, цэвэр зээл 1.4 хувийг тус тус эзэлж байна. 2012 онд улсын төсвийн зарлагын гүйцэтгэл 4,379.4 тэрбум төгрөг буюу 93.6 хувиар хангагдсан бөгөөд гүйцэтгэлийг ТЕЗ-аар харуулбал,

Хүснэгт №16

(сая төгрөг)

№	ТЕЗ	Төсөв	Гүйцэтгэл	Үүнээс			Хэтрэлт (-), хэмнэлт (+)	Эзлэх хувь
				Урсгал	Хөрөнгийн	Цэвэр зээл		
1	БШУС	961,231.9	897,110.6	770,253.0	120,434.2	6,423.4	64,121.3	20.37
2	БСШУС	1,327.5	1,172.6				154.8	0.03
3	ХАХНХС	569,442.6	524,542.5	474,885.9	49,656.6		44,900.0	11.91
4	НХХС	25,523.2	21,769.8	21,769.8			3,753.4	0.49
5	ХС	214,124.3	190,936.5	125,623.9	16,705.2	48,607.4	23,187.8	4.34
6	ҮХААС	167,564.1	133,183.4	79,812.7	76,994.1	(23,623.4)	34,380.7	3.02
7	ХХААХҮС	5,093.5	4,843.3	4,843.3			250.2	0.11
8	ЗТС	498,372.6	444,790.7	15,309.5	429,481.2		53,582.0	10.10
9	ЗТБХБС	2,285.7	1,756.1	1,756.1			529.6	0.04
10	БХБС	107,712.1	84,344.3	11,732.6	72,611.7		23,367.8	1.92
11	ЭМС	455,595.6	425,016.0	352,070.0	72,946.0		30,579.6	9.65
12	СС	405,251.0	420,635.1	358,066.2	26,679.2	35,889.6	(15,384.1)	9.55
13	ХЗС	303,597.5	316,195.3	275,730.0	43,431.0	(2,965.7)	(12,597.8)	7.18
14	ХЗДХС	1,353.9	1,346.0	1,346.0			7.9	0.03
15	ЭХС	181,100.4	175,809.1	38,327.2	137,481.9		5,291.3	3.99
16	ЭБЭХС	20,044.4	19,442.5	3,079.3	16,363.2		602.0	0.44
17	УУС	16,678.0	15,388.1	7,291.1	8,097.0		1,289.9	0.35
18	БХС	160,193.2	154,251.6	139,651.5	14,600.1		5,941.6	3.50
19	ССАЖС	122,120.1	115,921.1	71,095.1	44,826.0		6,199.0	2.63
20	БОНХС	92,021.8	80,916.3	57,045.2	23,871.2		11,105.4	1.84
21	БОАЖС	1,631.3	1,620.5	1,615.3	5.2		10.8	0.04
22	ШС	100,180.1	96,159.8	65,915.6	30,244.2		4,020.3	2.18
23	ЕС	68,090.5	65,309.5	32,231.5	33,078.0		2,781.0	1.48
24	ЭЗХС	16,317.3	15,045.7	2,626.8	12,418.9		1,271.6	0.34
25	ЗГХЭГ	47,638.4	44,847.8	15,273.1	29,574.7		2,790.6	1.02
26	ГХС	40,178.9	39,932.0	33,151.6	6,780.4		246.9	0.91
27	СЕХ	22,783.6	21,064.8	21,064.8			1,718.7	0.48
30	ШЕЗ	20,310.6	20,281.6	18,491.4	1,790.2		28.9	0.46
31	УИХ	18,427.3	16,251.8	15,127.7	1,124.1		2,175.5	0.37
32	УЕП	18,334.7	18,315.8	13,192.5	5,123.3		19.0	0.42

33	АТГ	8,427.0	8,163.5	7,075.4	1,088.1		263.5	0.19
34	ҮОНРТ	6,333.7	6,333.7	6,333.7			0.0	0.14
35	ЕТГ	6,184.4	5,821.2	4,855.3	965.9		363.1	0.13
36	ҮСХ	5,787.1	6,407.2	5,982.4	424.8		(620.1)	0.15
37	УДШЕШ	1,799.4	1,788.2	1,601.4	186.8		11.3	0.04
38	СЗХ	1,764.5	1,749.9	1,509.1	240.8		14.6	0.04
39	ҮАБЗ	1,367.1	1,314.4	1,251.9	62.5		52.7	0.03
40	ҮАГ	1,303.4	1,277.7	1,202.7	75.0		25.6	0.03
41	ЦАУЗБК	871.9	822.1	789.1	33.0		49.8	0.02
42	ТАЗ	632.7	625.5	585.5	40.0		7.2	0.01
43	ҮХЦ	551.8	547.0	496.8	50.2		4.8	0.01
44	ХЭҮК	433.2	428.8	428.8			4.4	0.01
	Дүн	4,699,982.3	4,403,479.5	3,061,663.4	1,277,484.7	64,331.4	296,502.7	100.0

Батлагдсан төсвийг Сангийн сайд, ХЗС, ҮСХ хэтрүүлэн зарцуулсан нь дамжуулан зээлдүүлсэн зээл, гадаад эх үүсвэрээр санхүүжиж байгаа төсөл, хөтөлбөрийн төлөвлөлтийг дутуу хийсэнтэй холбоотой байна. Тухайлбал:

- Сангийн яамны харьяа агентлагуудад гадаад зээлээр хэрэгжсэн 5 төсөл, арга хэмжээний урсгал зардлыг төлөвлөөгүйгээс 15.4 тэрбум төгрөгөөр зардлыг хэтрүүлэн зарцуулсан.
- ХЗС-ын багцад дамжуулан зээлдүүлсэн зээлээс 22.2 тэрбум төгрөгийг эргэн төлөгдөхөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2.9 тэрбум төгрөгийн зээлийг барагдуулж, үлдэгдэл 19.2 тэрбум төгрөгийг төсвийн зардлаар тайлагнасан.
- ҮСХ-нд Дэлхийн банкнаас санхүүжүүлж байгаа “Мон Стат” төслийн эх үүсвэрийг дутуу төлөвлөснөөс төсвийг 0.6 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн зарцуулснаар тайлагнасан байна.

Урсгал зардал. Улсын төсвийн 2012 оны гүйцэтгэлээр харуул хамгаалалтын 169.5, сургалт, хурал зөвлөгөөний 189.9, тээвэр, шатахууны 204.3, гадаад зочны 477.9, түүх, соёлын дурсгалт зүйл хамгаалах 488.7, бичиг хэргийн 676.1, эд, хогшил худалдан авах 2,760.1, урсгал засварын 2,875.9 сая төгрөгийн зардлууд тус тус хэтэрсэн байна.

ТЕЗ-даас багцын дүнгээр төсвөө хэтрүүлээгүй боловч зардлын зарим зүйлийг хэтрүүлсэн тохиолдол нилээдгүй байна. Тухайлбал:

- Бичиг хэргийн зардал: ХС, ЗТС, ЕС, ҮХАА, БХБС, ГХС, ССАЖС, ЭМС, БШУС 10.1-ээс 281.7 сая төгрөгөөр;
- Тээвэр, шатахууны зардал: ЗГХЭГ, БОНХС, ЕС, ССАЖС, ЭМС, ГХС, БШУС 11.9-өөс 259.8 сая төгрөгөөр;
- Эд хогшил худалдан авах: БХС, ХЗС, ШС, ЕС, БОНХС, ЗТС, ГХС, ССАЖС, СС, ЭМС, БШУС-ын багцууд 11.8-аас 1 522.1 сая төгрөгөөр;
- Төлбөр хураамжийн зардал: БХБС, БОНХС, ЗТС, УЕП, АТГ, ШЕЗ, ХАХНХС, ЕС, ХС, ҮХААС, ЭМС, ССАЖС, ГХС, БШУС, СС 13.0 саяас 880.6 сая төгрөгөөр;
- Гадаад зочны зардал: СС, ҮСХ, ЭМС, ЗТС, ЗГХЭГ, БХС, ГХС, ЕТГ 10.7 саяас 292.9 сая, нийт 625.3 сая төгрөгөөр;
- Сургалт, хурал зөвлөгөөний зардал: ЕС 10.1 сая, ЗТС 18.5 сая, ҮХААС 22.2 сая, БОНХС 33.8 сая, ГХС 183.1 сая, СС 789.3 сая, БШУС 1084.1 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна.
- Урсгал засварын зардал: АТГ, ҮАБЗ, УДШ, ХАХНХС, БХС, БОНХС, ХС, БХБС, ЕС, УЕП, ГХС, ҮХААС, ССАЖС, ШС, ХЗС, ЭМС, БШУС 10.2-1,629.6 саяар, нийт 3,366.5 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь олон жил ашиглагдсан барилгуудын дээвэр, цахилгаан, дулаан, сантехникийн шугамыг засварлах, тохижуулах, ажлын байрыг нүүлгэн шилжүүлэх зэрэг төлөвлөгдөөгүй зардал гарсантай холбоотой байна.
- Гадаад томилолтын зардал: ЭМС 22.7 сая, ШС 23.8 сая, УДШ 25.0 сая, АТГ 31.2 сая, ХЗС 41.0 сая, СС 56.2 сая, БШУС 97.6 сая, УУС 166.2 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна. Түүнчлэн ГХС 680.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Панам, Бутан, Кени улсуудтай шинээр дипломат харилцаа тогтоосон, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэснээс шалтгаалжээ.

Зардлын хэтрэлт нь Засгийн газрын бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор төсвийн тодотголоор бичиг хэрэг, тээвэр шатахуун, түлш халаалт, шуудан холбоо, дотоод албан томилолтын зардлыг бууруулж баталсантай зарим талаар холбоотой байна.

Түүнчлэн Сангийн сайдын 2010 оны 48 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын дагуу бараа үйлчилгээний зардлын зүйлээр бүлэглэн, бүлэг дотроо шилжүүлэн зарцуулсан, дутуу төлөвлөсөн, зарим бараа материалын үнэ өссөн зэрэг нь зардлын хэтрэлтэд нөлөөлсөн, зарим төрлийн зардлууд хүрэлцэхгүй байхад зарим нь хэмнэгдсэн нь төсвийг бодитой төлөвлөж чадахгүй байгаатай холбоотой байна.

Урсгал шилжүүлгийн зардал. Нийт 732.4 тэрбум төгрөг батлагдсанаас гүйцэтгэл 641.5 тэрбум төгрөг буюу 87.6 хувь байгаа ч өмнөх онтой харьцуулахад 2.1 дахин нэмэгдэж, зардлын өсөлтийн томоохон хувийг эзэлж байна.

Энэ нь 2012 онд зарим нэр төрлийн зардал шинээр нэмэгдсэн, тэтгэмж шинээр авагчдын тоо нэмэгдсэн, сонгуулийн үр дүнгээр бүтцийн өөрчлөлт хийснээс шалтгаалжээ. Тухайлбал:

- Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилж, УИХ-аар батлагдсанаар их, дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудад 2012 оноос эхлэн сар бүр олгосон 70.0 мянган төгрөгийн тэтгэлэгт 102.3 тэрбум, гадаадад суралцагсдын зардалд 18.7 тэрбум, хоол тэжээлийн дэмжлэг, тусламж 8.4 тэрбум, сонгуулийн үр дүн болон бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох нөхөн олговорт 1.0 тэрбум төгрөгийг олгосон;
- УИХ-д суудалтай намд төсвөөс олгох дэмжлэг, халамжийн тэтгэвэр, амжиргааг дэмжих болон нөхцөлт мөнгөн тусламж, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, шагнал, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох тэтгэмж, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, шүүхийн шийдвэр болон төрийн албан хаагчийн буруутайгаас үүссэн хохирлыг барагдуулах зэрэг зардал өмнөх онтой харьцуулахад 1.2-оос 10.5 дахин нэмэгдсэнтэй холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт. 2012 онд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 3,570.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1406 арга хэмжээнд 1,489.6 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд тодотголоор 1,208.4 тэрбум төгрөг болж, 281.1 тэрбум төгрөгөөр хасагдсан байна.

2012 онд төсвийн орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор улсын төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оныхоос 275.3 тэрбум төгрөгөөр буюу 22.8 хувиар өсчээ.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг бүтцээр нь авч үзвэл, барилга байгууламжид 85.0 хувь, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил худалдан авахад 10.0 хувь, их засварын зардалд 5.0 хувийг зарцуулахаар баталсан байна.

Тайлант онд барилга байгууламжид зарцуулахаар батлагдсан хөрөнгө нь өмнөх оныхоос 261.1 тэрбум төгрөг буюу 25.2 хувиар, тоног төхөөрөмж худалдан авах зардал 8.8 тэрбум төгрөгөөр буюу 7.2 хувиар, их засварын зардал 5.4 тэрбум төгрөгөөр буюу 10.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант онд 953.6 тэрбум төгрөгийн 2090 хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 103.5 тэрбум төгрөгийн 220 ажил дутуу, 214.3 тэрбум төгрөгийн 108 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг тусад нь тайлагнасан болно.

3.3. Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

2012 оны орон нутгийн төсвийн нийт зарлага 950.6 тэрбум төгрөгөөр батлагдаж 78.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлагад орон нутгийн төсвийн зарлага 17.6 хувьд хүрч өмнөх оноос 9.4 пунктээр өсчээ. Зарлагын бүтцийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №17

(тэрбум төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, Хэмнэлт	Гүйцэтгэл хувь	Эзлэх хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	950.6	747.2	203.4	78.0	100.0
Цалин, НДШ	116.6	112.9	3.7	96.8	15.1
Бараа үйлчилгээний бусад зардал	158.9	140.8	18.1	88.6	18.8
Татаас ба урсгал шилжүүлэг	292.1	247.5	44.6	84.7	33.1
Хөрөнгийн зардал	382.9	246.0	136.9	64.2	32.9

Нийт зарлагад урсгал зардал 33.9 хувь, хөрөнгийн зардал 32.9 хувийг эзэлж байна.

Аймаг, нийслэлийн төсвийн 2012 оны зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №18

сая төгрөг

Аймаг, нийслэл	Төсвийн зарлага			Аймаг, нийслэл	Төсвийн зарлага		
	Төл	Гүйц	Хувь		Төл	Гүйц	Хувь
Архангай	9,957.0	9,462.5	95.0	Өмнөговь	40,511.9	40,276.5	79.0
Баян-Өлгий	7,475.9	7,815.5	104.5	Сүхбаатар	9,428.1	9,703.8	102.9
Баянхонгор	10,146.2	9,653.3	95.1	Сэлэнгэ	15,764.0	15,230.3	96.6
Булган	9,026.4	8,443.2	93.5	Төв	12,240.8	13,341.0	109.1
Говь-Алтай	11,787.0	10,959.5	93.0	Увс	9,380.8	9,603.9	102.4
Говьсүмбэр	4,123.0	3,951.7	95.8	Ховд	9,160.1	9,289.6	101.4
Дорноговь	13,789.5	12,481.4	92.4	Хөвсгөл	13,096.8	12,576.7	96.0
Дорнод	10,725.1	10,136.0	94.5	Хэнтий	9,577.7	9,282.6	96.9
Дундговь	7,416.5	7,068.8	95.3	Дархан-Уул	8,817.6	8,529.9	96.7
Завхан	9,950.9	10,180.3	102.3	УБ	423,514.6	267,738.7	63.2
Өвөрхангай	11,300.2	11,381.8	100.7	Орхон	12,634.5	13,264.5	105.0
Бүгд дүн					669,824.8	510,371.8	76.2

2012 онд батлагдсан төсвийг Төв, Орхон, Баян-Өлгий, Сүхбаатар, Завхан, Увс, Ховд, Өвөрхангай зэрэг аймгууд 81.6-1,100.3 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ. Тухайлбал:

- Баян-Өлгий, Ховд аймаг өмнөх оны орон нутгийн давсан орлого болон 2012 оны орлогын зарим хэсгийг аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр зарцуулсан,
- Сүхбаатар аймагт орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайланг нэгтгэсэнтэй холбоотой зардлын дүн өссөн, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахдаа улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тохируулах бичилт хийгээгүй,

- Увс аймаг давсан орлогын дүнгээр төсвийн зардлаа өсгөж баталсан,
- Төв аймаг оны эхний үлдэгдлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр зарцуулсантай тус тус холбоотой байна.

Давсан орлогын дүнгээр аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор төсвийн тодотгол хийсэн нь зардал хэтрэхэд нөлөөлжээ. Тухайлбал:

- *Дундговь аймгийн Дэрэн, Говь-Угтаал сумд төсвийн тодотголыг сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн тогтоол гаргаж шийдвэрлэсэн,*
- *Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Баян-Овоо, Булган сумдын ЗДТГ-ууд 2.4-30.6 сая төгрөгөөр төсвөө хэтрүүлэн зарцуулсан байна.*

Орон нутгийн урсгал зардал. 2012 оны орон нутгийн төсвийн урсгал зарлага өмнөх оноос 61.7 тэрбум төгрөгөөр өсч 253.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүний 22.5 хувийг цалин, НДШ, 28.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 49.4 хувийг татаас ба урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Төв аймаг батлагдсан төсвийг 1,100.3 сая төгрөг буюу 9.0 хувиар хэтрүүлэн зарцуулжээ. Тухайлбал,

Аймгийн ИТХ-ийн 2012.12.14-ны өдрийн 04 дүгээр тогтоолын дагуу

- *Сумдын болон орон нутгийн төсвийн байгууллагуудын өрийг барагдуулахад 132.0 сая;*
- *Аймгийн ИТХ-ын ажлын албанд суудлын автомашин худалдан авахад 139.8 сая;*
- **Жаргалант сумын ИТХ-ын тогтоолын дагуу**
- *Суманд ажилласан гадаадын харьяат иргэдээс оруулсан ажиллах хүчний төлбөрт 256.1 сая;*
- **2011 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар төлөвлөгөөнд батлагдсан**
- *Эрдэнэ сумын Босгын гармын гүүр 85.9 сая;*
- *Сүмбэр сумын Загдалын голын гүүр 34.9 сая;*
- *Лүн сумын мал эмнэлгийн ариун цэврийн постын барилгын ажил 157.1 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгосон нь төсөв хэтрэхэд нөлөөлсөн байна.*

Мөн Сүхбаатар аймгийн төсвийн гүйцэтгэлээр нийт зарлага 275.7 сая төгрөгөөр хэтэрсэн нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайланг нэгтгэсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн зардал. 2012 оны орон нутгийн төсвийн хөрөнгийн зардал өмнөх оноос 69.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 246.0 тэрбум төгрөгт хүрч, нийт зарлага санхүүжилтийн 48.2 хувийг эзэлж байгаа нь орон нутгийн дотоод эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалтын санхүүжилт өссөнийг харуулж байна.

Үүнээс төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зардлаас 136.7 тэрбум төгрөг буюу 96.4 хувийг барилга байгууламж, 8.9 тэрбум төгрөг буюу 3.6 хувийг тоног төхөөрөмж худалдан авахад тус тус зарцуулсан байна.

3.4. Хүний хөгжил сангийн зарлагын гүйцэтгэл

2012 оны тодотголоор ХХС-гийн төсвийн зардлыг батлагдсан төсвөөс 78.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ. Үүнд:

- *Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд заасны дагуу төрөөс хариуцах оюутны эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 1.3 тэрбум төгрөг,*
- *УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу 0-18 насны нийт 978.1 мянга орчим хүүхдэд 10-12 саруудад сар бүр 20.0 мянган төгрөгийг бэлэн мөнгө хэлбэрээр олгоход 5.7 тэрбум төгрөг,*
- *Нэгдсэн төсвийн болон Төв банкны тухай хууль, Засгийн газрын 2012 оны 24 дүгээр тогтоолын дагуу ХХС-гийн төсвийн орлогын зөрүүг нөхөх зориулалтаар Монгол банкнаас авсан зээлийн хүүгийн төлбөрт 18.9 тэрбум төгрөг тус тус нэмсэн байна.*

2012 онд 866.0 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсанаас 848.7 тэрбум төгрөг зарцуулж, 17.3 тэрбум төгрөгийн хэмнэлттэй буюу 98.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Зардлын задаргааг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №19

(сая төгрөг)

Зардлын төрөл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сар бүр олгох 21.0 мянган төгрөг	358,400.4	374,680.0	(16,279.6)	44.1
Иргэдэд олгох 1.0 сая төгрөг	334,200.0	318,567.4	15,632.6	37.5
Оюутны сургалтын төлбөр	83,633.2	71,148.6	12,484.6	8.4
Хүүхдэд олгох мөнгө	58,684.4	53,264.1	5,420.3	6.3
Хүүгийн төлбөр	18,977.3	18,930.5	46.8	2.2
Төр хариуцах иргэдийн ЭМД-ын шимтгэл	12,151.5	12,151.5	0.0	1.4
Нийт зарлагын дүн	866,046.8	848,742.1	17,304.7	100.0

Иргэнд сар бүр олгох 21.0 мянган төгрөгийн хишиг хувийг 2012 онд 2,800.0 мянган иргэнд 358.4 тэрбум төгрөг олгохоор баталсан боловч гүйцэтгэлээр 16.3 тэрбум төгрөг хэтрүүлэн зарцуулсан нь урьд онуудад хишиг хувиа аваагүй иргэд болон 2012 онд шинээр төрөгсдөд олгосонтой холбоотой байна.

Засгийн газрын 2012 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртэх журам”-д ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1.0 сая хүртэлх төгрөгийн хишиг, хувийг хүртээхээр өөрчлөлт оруулсны дагуу 334.2 тэрбум төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 2,823.9 мянган иргэнд 318.6 тэрбум төгрөг олгож, 15.6 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн нь журмын 9.1-д “... иргэн хишиг, хувь хүртэх хүсэлтээ сум хорооны нийгмийн ажилтанд бичгээр гаргана” гэж заасны дагуу зөвхөн хүсэлт гаргасан иргэдэд олгосноос шалтгаалсан байна.

Засгийн газрын 2011 оны 245 дугаар тогтоолын дагуу 170.0 мянган оюутанд 83.6 тэрбум төгрөгийг сургалтын төлбөр хэлбэрээр хишиг хүртээхээр төлөвлөснөөс 144.6 мянган оюутанд 71.1 тэрбум төгрөгийг олгосон байна.

Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам”-ын 2.1-д “Хүүхдийн эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, иргэмжлэгдсэн этгээд) эсхүл 16 насанд хүрсэн бол хүүхэд өөрийн биеэр хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргах эрхтэй” гэж заасны дагуу мөнгө авах хүсэлт гаргасан давхардсан тоогоор нийт 2.7 сая хүүхдэд 53.3 тэрбум төгрөг зарцуулжээ.

Төрөөс хариуцах иргэний эрүүл мэндийн даатгалаар 16 хүртэлх насны 938,6 мянган хүүхэд, их, дээд сургуулийн өдрийн ангийн 155.1 мянган суралцагч, хугацаат цэргийн 6.1 мянган албан хаагч, хүүхдээ асарч буй 88.1 мянган эх, өндөр насны тэтгэвэртэй 226.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй 60.2 мянга, халамжийн тэтгэвэр авагч 37.2 мянга, нийт 1.5 сая иргэний ЭМД-д 12.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

3.5. Нийгмийн даатгалын сангийн зарлагын гүйцэтгэл

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2012 оны 1 дүгээр тогтоолоор НДС-гийн зардлыг 942.2 тэрбум төгрөгөөр тодотгон баталсан байна.

НДС-гаас давхардсан тоогоор 4,599.3 мянган даатгуулагчийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардалд 900.3 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардалд нийт 18.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулжээ. Зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №20

Үзүүлэлт	2011 оны гүйцэтгэл	2012 он		Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Тэтгэврийн даатгалын сан	441,065.6	711,075.1	709,674.5	1,400.6	99.8
Тэтгэмжийн даатгалын сан	31,358.6	40,447.2	42,613.4	(2,166.2)	105.4
ҮОМШӨ-ний даатгалын сан	19,205.2	27,942.9	26,756.4	1,186.6	95.8
Ажилгүйдлийн даатгалын сан	7,108.2	10,151.9	6,907.6	3,244.4	68.0
Эрүүл мэндийн даатгалын сан	87,221.2	131,776.3	114,396.4	17,379.8	86.8
Үйл ажиллагааны зардал	11,918.1	16,985.2	16,486.9	498.4	97.1
Хөрөнгө оруулалт	2,365.5	3,814.3	1,853.2	1,961.1	48.6
ДҮН	600,242.4	942,192.9	918,688.4	23,504.7	

Тайлант хугацаанд НДС-гаас олгох тэтгэмжийн даатгалаас бусад зардлыг 25.7 тэрбум төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зардлын талаар. 2012 онд 4 төрлийн тэтгэвэрт нийт 709.7 тэрбум төгрөг зарцуулжээ. Үүнийг өмнөх онтой харьцуулбал:

Хүснэгт №21

(мянган тэтгэвэр авагч, тэрбум төгрөг)

Тэтгэврийн төрөл	2011 он		2012 он		+/ өсөлт, -/ бууралт	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Өндөр насны	205.0	328.7	210.9	516.7	5.9	187.9
Тахир дутуугийн	50.8	53.5	50.5	88.1	(-0.3)	34.5
Тэжээгчээ алдсаны	25.0	28.0	23.9	43.1	(-1.1)	15.1
Цэргийн	14.3	30.6	14.9	61.8	0.6	31.2
НИЙТ	295.1	440.8	300.1	709.4	5.0	268.6

Засгийн газрын 2012 оны 80 дугаар тогтоолоор 2012 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс бүх төрлийн тэтгэврийн хэмжээг 35.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, 153 дугаар тогтоолоор 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс шинэчлэн тогтоосон, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 180.3 мянга, өндөр насны дундаж тэтгэвэр 222.6 мянган төгрөгт хүрсэнтэй холбоотойгоор тэтгэврийн зардал 268.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт тэтгэвэр авагчдын 17.6 хувь буюу 52.8 мянган иргэн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байна.

1960 оноос хойш төрсөн иргэдийн тэтгэврийн санд төлсөн шимтгэлийг 2014 оноос эхлэн тэтгэвэрт зарцуулахгүйгээр хуримтлуулах, нэрийн дансны гарааны үлдэгдэл болон өмнөх (1999-2013) жилүүдийн тэтгэвэрт зарцуулсан дүнг Засгийн газартай тооцоо нийлж, нэрийн дансыг мөнгөжүүлэх арга хэмжээ авах, хөрөнгө оруулалтаар арвижуулах арга хэлбэрийг тогтоох ажил хийгдээгүй байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн зардлын талаар: 2012 онд 150.3 мянган даатгуулагчдад 42.6 тэрбум төгрөг зарцуулснаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 98.9 мянган иргэнд 8.1 тэрбум, жирэмсэн болон амаржсан 38.5 мянган иргэнд 30.6 тэрбум, 12.9 мянган иргэнд оршуулгын зардалд 3.9 тэрбум төгрөгийг олгож 2.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, даатгуулагчийн дундаж цалин болон тооны өсөлтөөс хамаарчээ.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зардлын талаар. Тахир дутуу болон тэжээгчээ алдсан 6.7 мянган иргэний тэтгэвэрт 24.7 тэрбум, хөдөлмөрийн чадвар түр алдсан 798 иргэний тэтгэмжид 322.1 сая, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд 4,478 даатгуулагчдад 830.8 сая, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 124.0 сая төгрөг, тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлд 712.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Ажилгүйдлийн даатгалын сангийн зардлын талаар. Сангаас 6,855.8 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын тэтгэмж, 2.5 сая төгрөгийг сургалтын зардалд, 40.3 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийн албаны үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулжээ.

Ажилгүйдлийн тэтгэмжийн зардал өмнөх оноос 203.4 сая төгрөгөөр буурсан нь 2009 онд ажилгүйдлийн тэтгэмж олгох хугацааг 50 хоногоор нэмэх хуулийн заалтын үйлчлэх хугацаа 2011 онд дууссанаас шалтгаалжээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын талаар: 2012 онд 4,126.4 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардалд 114.3 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт №22

(мянган хүнээр, тэрбум төгрөгөөр)

Тусламж үйлчилгээ	2011 он		2012 он		/+/- өсөлт, /-/- бууралт	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Эмнэлэг	2,525.3	81.8	3,364.7	105.5	839.4	23.7
Сувилал	50.3	2.4	54.9	3.9	4.6	1.5
Эмийн үнийн хөнгөлөлт	622.8	3.0	706.9	4.9	84.1	1.9
НИЙТ ДҮН	3,198.4	87.2	4,126.4	114.3	928.0	27.1

Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж төлбөр тусламж авсан иргэдийн тоо урьд оноос 928.0 мянган иргэдээр нэмэгдэж, олгосон хөрөнгө 27.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

НДС-гийн хөрөнгө оруулалт. НДБ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 1,853.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг сангаас санхүүжүүлжээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос 10.3 хувь буюу 173.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №23

(сая төгрөг)


Зардал	2011 он	2012 он	/+/- өсөлт, /-/- бууралт	
			Хувь	Тоо
Барилга байгууламж, их засвар	705.5	1,015.0	43.9	309.5
Тоног төхөөрөмж	292.2	457.1	56.4	164.9
Тээврийн хэрэгсэл	508.8	241.3	-52.6	-267.5
Тавилга, эд хогшил	173.4	139.8	-19.4	-33.6
НИЙТ ДҮН	1,679.9	1,853.2	10.3	173.1

Бүлэг 4. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцэл

УИХ 2012 онд нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 960.5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн нийт тэнцэл 862.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан бөгөөд нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр урсгал тэнцэл 418.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 1,136.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Зураг №5

Улсын нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэлийг харуулбал:



2012 онд гадаад зээлийн үндсэн төлбөрт 85.7 тэрбум, дотоод зээлийн үндсэн төлбөрт 223.4 тэрбум төгрөг, дотоод бондын үндсэн төлбөрт 187.9 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

Мөн төсвийн тэнцлийг хангах зорилгоор 240.7 тэрбум төгрөгийн төслийн зээл, 30.9 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл, 63.2 тэрбум төгрөгийн урьдчилгаа орлого, 5.9 тэрбум төгрөгийн өмч хувьчлалын орлого, Засгийн газрын үнэт цаасны арилжаанаас 13.7 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг тус тус ашигласан байна.

Улсын төсвийн тэнцэл. Улсын төсвийн урсгал тэнцэл 651.0 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 413.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, урсгал тэнцэл 2.7 тэрбум, нийт тэнцэл 993.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2012 онд Засгийн газрын үнэт цаасны эргэн төлөлтөнд 194.1 тэрбум төгрөг, ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үндэсний үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор гаргасан бондын төлбөрт 102.9 тэрбум төгрөг, “4000 айлын орон сууц” хөтөлбөрт зориулан гаргасан бондын төлбөрт 65.0 тэрбум төгрөг, Банкны бүтцийн өөрчлөлтөд зориулан гаргасан үнэт цаасны төлбөрт 20.0 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

Эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх зорилгоор УИХ-ын 2012 оны 112 дугаар тогтоолоор олгосон эрхийн дагуу Олон улсын зах зээлд гаргасан Чингис бонд арилжаалсны орлого 2,088.1 тэрбум төгрөгийн, улсын төсвийн алдагдал, улирлын чанартай орлогын дутагдлыг нөхөх зорилгоор УИХ-ын 2012 оны 21, 28 дугаар тогтоолоор олгосон эрхийн дагуу нийт 554.9 тэрбум төгрөгийн, Жижиг, дунд үйлдвэр, ноос, ноолуурын салбарыг дэмжих зорилгоор УИХ-ын 2011 оны 30 дугаар тогтоолын дагуу 13.7 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалж, Засгийн газрын үнэт цаасны 499.7 тэрбум төгрөгөөр улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлжээ.

Гадаад зээлийн үндсэн төлбөрт 89.1 тэрбум төгрөг төлж, хандивлагч орон, Олон улсын санхүүгийн байгууллагаас 271.7 тэрбум төгрөгийн гадаад зээл авч, өмч хувьчлалын орлогоор 1.2 тэрбум төгрөг төвлөрүүлж улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлжээ.

Орон нутгийн төсвийн тэнцэл. Орон нутгийн төсвийн нийт тэнцэл 83.1 тэрбум төгрөгийн алдагдалтай, үүний 3.6 тэрбум төгрөгийг орон нутгийн өмч хувьчлалын орлогоор, 1.9 тэрбум төгрөгийг Засгийн газрын зээлээр, үлдсэн 77.5 тэрбум төгрөгийг орон нутгийн харилцах дансны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлээр нийт тэнцэл 110.8 тэрбум төгрөгийн ашигтай гарч, өмч хувьчлалын орлогоор 4.7 тэрбум төгрөг төвлөрч, улмаар орон нутгийн харилцах дансны үлдэгдэл 115.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүний хөгжил сангийн төсвийн тэнцэл. ХХС-гийн нийт тэнцэл 416.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, үүний 313.1 тэрбум төгрөгийг УИХ-ын 2012 оны 64 дүгээр тогтоолоор олгосон эрхийн дагуу Засгийн газрын үнэт цаасны арилжааны орлогоор, 228.0 тэрбум төгрөгийг төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг түр хугацаагаар нөхөх зориулалтаар, 80.0 тэрбум төгрөгийг төслийн урьдчилгаа орлогоор, үлдсэн 23.4 тэрбум төгрөгийг тус сангийн харилцах дансны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Хүний хөгжил сангийн гүйцэтгэлээр нийт тэнцэл 407.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, 228.0 тэрбум төгрөгийн төсвийн улирлын чанартай орлого, зарлагын зөрүүг түр хугацаагаар нөхөх зориулалтаар авсан зээлийг төлж, төслийн урьдчилгаа орлогоор 63.2 тэрбум төгрөг төвлөрч, улмаар сангийн харилцах дансны эхний үлдэгдэл 31.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл. Нийгмийн даатгалын сангийн нийт тэнцэл 50.4 тэрбум төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр нийт тэнцэл 153.3 тэрбум төгрөгийн ашигтай гарч, сангийн харилцах дансны эхний үлдэгдэл тэр хэмжээгээр нэмэгдсэн байна.

Нэгдсэн төсвийн тэнцлийн 2012 оны гүйцэтгэлийг өмнөх 3 жилийн дундаж болон 2011 оны гүйцэтгэлтэй харьцуулсан судалгааг төсвийн бүрэлдэхүүнээр харуулбал:

Хүснэгт №24


/сая төгрөг, хувь/

Эдийн засгийн ангилал	2009-2011 оны дундаж	2012 оны гүйцэтгэл	2012/2011	2012/дундаж (хувиар)
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	-375 159,5	- 1 136 628,6	147,6%	303,0
САНХҮҮЖИЛТИЙН ШААРДАГДАХ ЭХ ҮҮСВЭР	375 159,5	1 136 628,6	147,1%	303,0
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-191 099,1	- 1 702 895,0	780,4%	891,1
2. ЗГ-ын бонд	263 767,7	2 587 791,7	813,1%	981,1
3. ЗГ-ын зээл	142 895,0	182 588,4	93,9%	127,8
4. Урьдчилгаа төлбөр	153 823,0	63 194,7	13,7%	41,1
5. Урьдчилгаа төлбөрөөс орлого тооцох		16 800,0		
6. Өмч хувьчлал	5 772,9	5 948,9	43,0%	103,0
Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнээр)	8 697 621,8	13 944 238,1	125,8%	160,3

Эх сурвалж: Сангийн яам

Судалгаанаас харахад 2012 оны тэнцлийн алдагдал өмнөх 3 жилийн дунджаас 3 дахин, 2011 оноос бараг 47 хувиар нэмэгдсэн нь эдийн засаг өсөхийн хэрээр төсвийг тэлж байгаа болон орцод суурилсан төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Улсын нэгдсэн төсвийн сар, улирлын хуваарийн гүйцэтгэлийг авч үзвэл:
Зураг №6




Сангийн яамнаас батлагдсан төсвийн орлого, зарлагыг сараар тооцон хуваарилалтыг хийж ирсэн бөгөөд гүйцэтгэлтэй харьцуулахад зарлагын түвшин оны эхний саруудад өндөр, оны эцэс рүү зарлага хязгаарлагдсан байна.

Улс ба орон нутгийн төсвийн харилцаанд гарч байгаа томоохон өөрчлөлтийг ДНБ-д эзлэх төсвийн орлого, зарлагын өсөлтийн өөрчлөлт харуулж байна. Улсын төсвийн орлого, зарлагын үзүүлэлтийн түвшинг 2007-2012 оны байдлаар ДНБ-д эзлэх байдлаар нь авч үзвэл:

Зураг №7

Монгол Улсын 2007-2012 оны төсвийн орлого, зарлагын үзүүлэлт




Төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2007 онд 35.9 хувь, 2012 онд 24.3, зарлага 2007 онд 33.3 хувь байсан бол 2012 онд 31.4 хувь болжээ. Тухайн жилүүдийн динамикаас харахад төсвийн хуваарилалт жигд бус байгаа бөгөөд энэ нь нэг талаас эдийн засгийн өсөлттэй, нөгөө талаас макро түвшинд төсвийн орлого, зарлагын төлөвлөлт болон таамаглал бодит байдал, гүйцэтгэлтэй тэр бүр уялдахгүй байгаатай холбоотой юм.

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын үзүүлэлтийн түвшинг 2007-2012 оны байдлаар авч үзвэл:

Зураг №8

Орон нутгийн 2007-2012 оны төсвийн орлого, зарлагын үзүүлэлт



Орон нутгийн төсвийн ДНБ-д эзлэх орлогын хэмжээ 2007 онд 3.0 хувь байсан бол 2012 онд 6.2 хувь, зарлагын хэмжээ 2007 онд 2.9 хувь байсан бол 2012 онд 5.4 хувь болж өссөн нь эдийн засгийн өсөлттэй холбоотойгоос гадна тухайн жилүүдийн төсвийн төвлөрлийг сааруулах бодлоготой уялдаатай байна.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нөлөөлсөн хүчин зүйлс. 2012 оны гүйцэтгэлээр ДНБ-ий бодит өсөлт өмнөх оныхоос 2.9 пунктээр, уул уурхайн бус салбарын бодит өсөлт өмнөх оныхоос 6.3 пунктээр, үүнээс үйлчилгээний салбарын өсөлт өмнөх жилийнхээс 3.3 пунктээр тус тус буурсан нь төсвийн орлогын гүйцэтгэлд, улмаар төсвийн зардал, санхүүжилтэд нөлөөлсөн байна.

Хүснэгт №25

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Эдийн засгийн бодит өсөлт /хувь/	14.7%	12.3%	-2.4%
ДНБ-ий хэмжээ /оны үнээр, тбм.төг/	16,133.5	13,944.2	-2,189.3


2012 оны тодотгосон төсвийн дагуу нийт 22.7 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөсөн боловч жилийн эцсийн байдлаар нийт 21.0 сая тонн нүүрс экспортлосон байна.

Улсын 2012 оны нэгдсэн төсөвт хийсэн тодотголоор нийт 553.8 мянган тонн зэс экспортлохоор төлөвлөсөн ч жилийн эцсийн байдлаар нийт 516.6 мянган тонн зэс экспортод гарсан байна.

Манай улсын нүүрсний экспортын гол түншлэгч улсын эдийн засгийн өсөлт буурсан нь экспортын тоо, хэмжээ буурах, түүний дотор нүүрс олборлолтын үйл ажиллагаа явуулдаг томоохон ААНБ-уудын ашигт ажиллагаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, төсвийн орлогын бүрдүүлэлтэнд нөлөөлсөн байна.

Мөн Тавантолгойн нүүрсний ордыг ашиглахтай холбоотойгоор гарын үсгийн төлбөрийн орлого 496.4 тэрбум төгрөг, урьдчилгаа төлбөрийн эх үүсвэр 442.3 тэрбум төгрөг, бүгд 938.7 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэрийг төсвийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрт тусгасан нь төсвийн гүйцэтгэлд нөлөөлсөн ба төсвийн тодотгол хийсэн ч хэрэгжээгүй байна.

Төсвийн урсгал тэнцлийн ашиг ДНБ-ий 3.0 хувь, нийт тэнцлийн алдагдал ДНБ-ий 8.2 хувьтай тэнцэж байна.



Төсвийн орлогыг дагасан болон орцод суурилсан төсөв хийгдэж зарлагын өсөлт нэмэгдэж төсөв их хэмжээгээр тэлж байгаа ч гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ, олборлолт, экспорт буурч байгаа нь нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нөлөөлж байна. Иймээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангах зорилтот арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тухай. Татварын ерөнхий хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг гагцхүү хуулиар ноогдуулдаг. Одоогийн байдлаар нийт 17 төрлийн хуульд 39 төрлийн хөнгөлөлт, 181 төрлийн чөлөөлөлт буюу нийт 220 төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалт байна. Хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтуудыг тусгагдсан хуулийн нэр, төрлөөр нь авч үзвэл:

Хүснэгт №26

№	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлж буй хуулиуд	Заалтын тоо, Үүнээс:		
		Чөлөөлөлт	Хөнгөлөлт	Нийт
1	АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ	10	8	18
2	НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ	42	0	42
3	БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ (шинэчилсэн найруулга)	11	7	18
4	БУУНЫ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ	4	0	4
5	ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ	22	0	22
6	ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ	11	1	12
7	"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ	1	0	1
8	УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ	34	2	36
9	ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ	4	3	7
10	ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬ	16	6	22
11	ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ	7	0	7
12	"ЦАГААННУУР" ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ	2	5	7
13	"АЛТАНБУЛАГ" ХУДАЛДААНЫ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ	2	5	7
14	ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ	7	0	7
15	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ	1	0	1
16	АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ	4	1	5
17	УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ	3	1	4
НИЙТ		181	39	220

Хууль тогтоомжийн дагуу олгосон нийт татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2011 онд 1,114.8 тэрбум төгрөг буюу нэгдсэн төсвийн нийт татварын орлогын 30.4 хувь,

2012 онд урьдчилсан байдлаар 996.8 тэрбум төгрөгт хүрч нэгдсэн төсвийн нийт орлогын 23.7 хувьтай тэнцсэн байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бүртгэгдсэн зардлыг татварын хуулиар авч үзвэл, хамгийн өндөр буюу 72.1 хувь нь НӨАТ-ын тухай хуулийн хүрээнд, үлдэх хэсэг нь ГАТЧТХ, ААНОАТ-ын, ХХОАТ-ын, ОАТ-ын зэрэг хуулиудын хүрээнд тус тус татвараас чөлөөлөгдөж, хөнгөлөлт эдэлж байна.

Хүснэгт №27		(тэрбум төгрөг)		
№	Хууль	2011	2012	Эзлэх хувь
1	ААНОАТ-ын тухай	88.6	126.1	12.7
2	НӨАТ болон НӨАТ-аас чөлөөлөх тухай	905.9	718.2	72.1
3	ГТГАТТ болон ГАТ-аас чөлөөлөх тухай хууль	94.4	113.5	11.4
4	ХХОАТ-ын тухай	17.4	17.3	1.7
5	ОАТ-ын тухай	8.5	21.7	2.2
Нийт		1,114.8	996.8	100.0

Түүнчлэн улсын төсвийн татварын орлогын бүрдүүлэлтэд хийсэн судалгаагаар бүгд 74 ААНБ НӨАТ-ын хуулийн заалтын дагуу татвараас чөлөөлөгдсөн байна. Үүнд:

- Банк, даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 19 ААНБ /НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6.2/,
- Алт олборлож буй 13 ААНБ /НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.13/,
- Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй 2 ААНБ /НӨАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9/,
- Хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй 8 ААНБ
- НӨАТ-ын “0” хувьтай экспортын уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 6 ААНБ /НӨАТ-ын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7/,
- Бүлгээр НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн 1 ААН,
- Монгол улсад 2.0 сая ам.доллар ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн боловч үйл ажиллагаа нь жигдрээгүй 25 ААНБ,

Бүлэг 5. Дүгнэлт

Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Нэгдсэн төсвийн 2012 оны тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ тооцоолсноос 13.4 хувь буюу 755.7 тэрбум төгрөгөөр дутуу, нийт зарлага 6,017.8 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 1,136.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь төсвийн өрийн нийт хэмжээ өсөх, төсвийн тогтвортой байдал алдагдах эрсдлийг бий болгож байна.
2. Нэгдсэн төсвийн татварын орлого 16.1 хувиар буюу 803.9 тэрбум төгрөгөөр тасарсан нь татварын орлогын төлөвлөлт үндэслэл багатай, гүйцэтгэлд тавих хяналт сул, гадаад зах зээлийн эрсдэлийг бүрэн тооцоогүйтэй холбоотой байна.
3. Улсын нэгдсэн төсвийн 2012 оны нийт зарлага өмнөх 3 жилийн дундажтай харьцуулахад 72.4 хувиар, 2011 оныхоос 20.4 хувиар өссөн байна. Эдийн засгийн өөдрөг төсөөлөлд суурилан төсвийн орлогыг нэмэгдүүлэн төлөвлөж, тэр хэрээр зардлыг нэмэгдүүлж байгаа нь төсвийн орлого бүрдэхгүй тохиолдолд санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлд хүргэх, төсвийн тэнцлийн алдагдлыг ихэсгэх үр дагавар учруулж байна.
4. Хуульд заасан үндэслэлээр үзүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2012 онд 996.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн нийт орлогын 23.7 хувьтай тэнцсэн байна.
5. Орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлснээр аймаг, орон нутаг орлогоо нэмэгдүүлэх, бие даасан байдал нь хангагдах нөхцөл бүрдэж байгаа ч аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр зарлагаа өсгөх, төсвөө хэтрүүлэн зарцуулах, улсын төсвийн орлогыг төвлөрүүлэхгүй байх зөрчил илэрч байна.

Бүлэг 6. Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягт:

1. Төсвийн төслийг боловсруулах, Улсын Их Хурлаар батлуулах, төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлагыг хангахад анхаарч ажиллах,

Сангийн сайд Ч.Улаанд:

1. Төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах, зохион байгуулалт хяналтын тогтолцоог оновчтой, үр нөлөөтэй болгох, орлогын баазыг өргөтгөхөд чиглүүлэн төсвийн орлогын төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт, хяналт хариуцлагын хууль эрх зүйн зохицуулалт, өнөөгийн практик үйл ажиллагааг шинэчлэх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх,
2. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг оновчтой болгох, үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагыг үндэслэн гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах,
3. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж буй эрх зүйн орчин болон бодлогод дүн шинжилгээ хийж, оновчтой болгох санал боловсруулж, шийдвэрлүүлэх,
4. Төсвийн тухай хуулийн 56.3-д заасан хөшүүргийг ашиглаж орон нутгийн төсвийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах,

Хавсралт №1

МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	Нэгдсэн төсөв						Үүнээс:						Нийгмийн даатгалын сан		
	Урьдчилсан төсөв			Урьдчилсан төсөв			Орон нутгийн төсөв			Хүний хөгжил сан			Нийгмийн даатгалын сан		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,738,275.7	4,975,828.4	-762,447.3	4,364,194.9	3,481,171.9	-883,023.0	867,542.9	858,024.1	-9,518.7	449,508.1	440,972.2	-8,535.9	992,642.9	1,071,951.4	79,308.6
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	101,350.0	94,656.5	-6,693.5	101,350.0	94,656.5	-6,693.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1. УТ - Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	44,520.0	23,074.3	-21,445.7	44,520.0	23,074.3	-21,445.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. УТ - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	17,130.0	18,578.9	1,448.9	17,130.0	18,578.9	1,448.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3. УТ - Өсөн нэмэгдэх нөөцийн төлбөр	39,700.0	45,731.4	6,031.4	39,700.0	45,731.4	6,031.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. УТ - Бусад	0.0	7,271.9	7,271.9	0.0	7,271.9	7,271.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,636,925.7	4,881,171.9	-755,753.8	4,262,844.9	3,386,515.4	-876,329.4	867,542.9	858,024.1	-9,518.7	449,508.1	440,972.2	-8,535.9	992,642.9	1,071,951.4	79,308.6
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	5,624,806.2	4,846,063.9	-778,742.4	3,878,888.6	3,035,008.4	-843,880.2	704,702.6	695,843.0	-8,859.6	449,508.1	440,972.2	-8,535.9	720,213.3	799,221.9	79,008.6
1. Татварын орлого	5,007,311.5	4,203,321.5	-803,990.1	3,444,449.9	2,585,587.0	-858,862.9	631,646.7	612,781.0	-18,865.7	339,508.1	330,713.2	-8,794.8	720,213.3	799,221.9	79,008.6
1.1. Орлогын албан татвар	988,577.4	871,401.5	-117,175.9	658,677.5	524,381.8	-134,295.7	329,899.9	347,019.7	17,119.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	329,899.9	347,019.7	17,119.8	0.0	0.0	0.0	329,899.9	347,019.7	17,119.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын АТ	658,677.5	524,325.9	-134,351.6	658,677.5	524,325.9	-134,351.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн АТ	0.0	55.9	55.9	0.0	55.9	55.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	591,706.9	674,240.2	82,533.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	720,213.3	799,221.9	79,008.6
1.3. Өмчийн татвар	19,286.5	21,929.9	2,643.3	0.0	0.0	0.0	19,286.5	21,929.9	2,643.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,734,053.0	1,296,450.9	-437,602.1	1,734,053.0	1,296,450.9	-437,602.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	376,367.5	312,384.2	-63,983.3	376,367.5	312,384.2	-63,983.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.6. Тусгай зориулалтын орлого	32,362.6	33,977.5	1,614.9	10,517.6	10,814.6	297.0	21,845.0	23,163.0	1,317.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гаалийн албан татвар	565,955.9	327,369.8	-238,586.1	565,955.9	327,369.8	-238,586.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	699,001.6	665,567.4	-33,434.2	98,878.4	114,185.7	15,307.4	260,615.2	220,668.4	-39,946.7	339,508.1	330,713.2	-8,794.8	0.0	0.0	0.0
2. Татварын бус орлого	617,494.7	642,742.4	25,247.7	434,438.7	449,421.4	14,982.7	73,056.0	83,062.0	10,006.0	110,000.0	110,258.9	258.9	0.0	0.0	0.0
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	11,085.5	10,426.4	-659.1	0.0	0.0	0.0	11,085.5	10,426.4	-659.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1,034.0	24,681.7	23,647.7	383,956.3	351,507.0	-32,449.3	151,754.7	151,754.7	0.0	0.0	0.0	0.0	272,429.6	272,729.6	300.0

Хавсралт №2

МОНГО МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	Нэгдсэн төсөв						Уулзас,						Нийгмийн даатгалын сан					
	Төлөвлөгөө			Зөрүү			Төлөвлөгөө			Зөрүү			Төлөвлөгөө			Зөрүү		
	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү			
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,499,213.6	6,017,800.5	-481,413.0	4,675,982.3	4,379,479.5	-296,502.7	950,604.6	747,181.2	-203,423.4	866,046.8	848,742.8	-17,303.9	942,192.9	918,688.2	-23,504.7			
А. УРСГАЛ ЗАРЛАГА	4,664,348.3	4,428,111.6	-236,236.7	3,227,886.1	3,037,663.8	-190,222.3	567,649.8	501,161.1	-66,488.7	866,046.8	848,742.8	-17,303.9	938,378.6	916,835.1	-21,543.6			
1. Бараа, үйлчилгээний зардал	2,160,531.1	2,052,438.6	-108,092.5	1,966,734.2	1,895,444.6	-71,289.6	275,538.7	253,650.4	-21,888.3	0.0	0.7	0.7	34,606.8	16,168.9	-18,437.9			
1.1. Цалин, хөлс	1,216,403.7	1,197,164.8	-19,238.9	1,099,914.8	1,084,210.9	-15,703.9	105,046.3	101,795.9	-3,249.4	0.0	0.0	0.0	11,443.7	11,158.0	-285.6			
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	116,348.6	112,826.0	-3,522.7	102,765.2	99,897.5	-2,867.7	11,562.5	11,013.3	-539.2	0.0	0.0	0.0	2,030.9	1,915.1	-115.8			
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	944,127.4	855,273.8	-88,853.6	764,054.2	711,336.2	-52,718.0	158,941.0	140,841.2	-18,099.8	0.0	0.7	0.7	21,132.2	3,095.7	-18,036.5			
2.Зээлийн үйлчилгээний төлбөр	151,589.3	125,913.4	-25,675.9	132,612.0	106,982.8	-25,629.2	0.0	0.0	0.0	18,977.3	18,930.5	-46.8	0.0	0.0	0.0			
3.Татаас ба урсгал шилжүүлэг	2,352,227.9	2,249,759.6	-102,468.3	1,128,539.9	1,035,236.3	-93,303.5	292,111.0	247,510.7	-44,600.3	847,069.5	829,811.6	-17,257.8	903,771.8	900,666.2	-3,105.7			
3.1. Татаас	112,168.8	127,027.7	14,858.9	396,103.3	393,764.0	-2,339.3	1,111.1	1,107.0	-4.1	0.0	0.0	0.0	89,526.6	94,902.2	5,375.6			
3.2. Урсгал шилжүүлэг	2,240,059.0	2,122,731.9	-117,327.2	732,436.6	641,472.4	-90,964.2	290,999.9	246,403.7	-44,596.2	847,069.5	829,811.6	-17,257.8	814,245.2	805,763.9	-8,481.3			
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,849,642.9	1,525,357.6	-324,285.3	1,462,873.8	1,277,484.3	-185,389.5	382,954.8	246,020.1	-136,934.7	0.0	0.0	0.0	3,814.3	1,853.2	-1,961.1			
1. Хөрөнгө оруулалт	1,529,852.7	1,307,864.0	-221,988.7	1,152,612.8	1,068,905.3	-83,707.5	373,807.0	237,105.5	-136,701.5	0.0	0.0	0.0	3,432.9	1,853.2	-1,579.7			
2. Их засвар	56,166.8	53,480.4	-2,686.4	55,776.9	53,471.9	-2,305.0	8.5	8.5	0.0	0.0	0.0	0.0	381.4	0.0	-381.4			
3. Хөрөнгийн бусад зардал	80,859.0	66,517.0	-14,342.0	71,719.7	57,610.9	-14,108.8	9,139.3	8,906.1	-233.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0			
4. Төслийн зээлээр санхүүжих хөрөнгийн зардал	182,764.4	97,496.2	-85,268.2	182,764.4	97,496.2	-85,268.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0			
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	-14,777.7	64,331.4	79,109.0	-14,777.7	64,331.4	79,109.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0			
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-33,618.4	11,543.0	45,161.4	-33,618.4	11,543.0	45,161.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0			
2 Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	18,840.7	52,788.4	33,947.7	18,840.7	52,788.4	33,947.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0			

Хавсралт №3

МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Үзүүлэлт	Нэгдсэн төсөв		Уулсын төсөв		Орон нутгийн төсөв		Хүний хөгжил сан		Нийгмийн даатгалын сан	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,738,275.7	4,975,828.4	4,364,194.9	3,481,171.9	867,542.9	858,024.1	449,508.1	440,972.2	992,642.9	1,071,951.4
ТОГВОРЖУУЛАЛТЫН САН	101,350.0	94,656.5	101,350.0	94,656.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,636,925.7	4,881,171.9	4,262,844.9	3,386,515.4	867,542.9	858,024.1	449,508.1	440,972.2	992,642.9	1,071,951.4
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	5,624,806.2	4,846,063.9	3,878,888.6	3,035,008.4	704,702.6	695,843.0	449,508.1	440,972.2	720,213.3	799,221.9
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,499,213.6	6,017,800.5	4,675,982.3	4,379,479.5	950,604.6	747,181.2	866,046.8	848,742.8	942,192.9	918,688.2
ТӨСВИЙН - Урсгал	960,457.9	417,952.3	651,002.5	-2,655.4	137,052.9	194,681.9	-416,538.7	-407,770.7	-218,165.3	-117,613.2
ТЭНЦЭЛ - Нийт	-862,287.9	-1,136,628.6	-413,137.4	-992,964.1	-83,061.7	110,842.9	-416,538.7	-407,770.7	50,449.9	153,263.2
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР:	862,287.9	1,136,628.6	413,137.4	992,964.1	83,061.7	-110,842.9	416,538.7	407,770.7	-50,449.9	-153,263.2
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	169,701.1	-1,702,895.0	119,164.3	-1,465,534.6	77,538.5	-115,573.1	23,448.1	31,476.0	-50,449.9	-153,263.2
3. ЗГ-ын бонд	489,725.0	2,587,791.7	176,625.0	2,274,691.7	0.0	0.0	313,100.0	313,100.0	0.0	0.0
3.1. Урт хугацаат	-217,075.0	1,913,883.9	-217,075.0	1,913,883.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.1. Дотоод	-217,075.0	-174,266.1	-217,075.0	-174,266.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.1.2. Гадаад	0.0	2,088,150.0	0.0	2,088,150.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.2. Богино хугацаат	706,800.0	673,907.8	393,700.0	360,807.8	0.0	0.0	313,100.0	313,100.0	0.0	0.0
3.2.1. Дотоод	706,800.0	673,907.8	393,700.0	360,807.8	0.0	0.0	313,100.0	313,100.0	0.0	0.0
3.2.1.1. Шинээр гаргах	896,800.0	867,959.4	583,700.0	554,859.4	0.0	0.0	313,100.0	313,100.0	0.0	0.0
3.2.1.2. Үндсэн төлбөр	-190,000.0	-194,051.6	-190,000.0	-194,051.6	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4. ЗГ-ын зээл	117,788.1	182,588.4	115,848.1	182,588.4	1,940.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1. Дотоод	-3,340.0	-3,426.4	-3,340.0	-3,426.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.1. Монголбанк (ОУВС)	-3,340.0	-3,426.4	-3,340.0	-3,426.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.1.1.1. Шинээр гаргах	152,000.0	220,000.0	0.0	0.0	0.0	0.0	152,000.0	228,000.0	0.0	0.0
4.1.1.2. Үндсэн төлбөр	-155,340.0	-223,426.4	-3,340.0	-3,426.4	0.0	0.0	-152,000.0	-228,000.0	0.0	0.0
4.2. Гадаад	121,128.0	186,014.8	119,188.0	186,014.8	1,940.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1. Төслийн зээл	121,128.0	155,064.0	119,188.0	155,064.0	1,940.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1.1. Шинээр авах	210,277.0	240,744.6	208,337.0	240,744.6	1,940.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.1.2. Үндсэн төлбөр	-89,148.9	-85,680.5	-89,148.9	-85,680.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
4.2.2. Хөтөлбөрийн болон төслийн бус зээл	0.0	30,950.8	0.0	30,950.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
5. Урьдчилгаа орлого	79,990.6	63,194.7	0.0	0.0	0.0	0.0	79,990.6	63,194.7	0.0	0.0
6. Өмч-хувь-члал	5,083.2	5,948.9	1,500.0	1,218.6	3,583.2	4,730.2	0.0	0.0	0.0	0.0



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ**

2013 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Монгол Улсын 2012 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд нарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2014 оны 1 дүгээр сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Сангийн сайдад зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Б.Баттуяад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070393

